

## ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ 2009 ОНЫ 2 ДУГААР САРЫН ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

### Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн салбарт:

Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын талаар. “Өрхийн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулах ажлын хэсгийн хурлыг зохион байгуулан, ядуу өрхийн шинж байдлыг тодорхойлох матрицыг боловсруулав. Хөтөлбөрт хамрагдах ядуу, нэн ядуу иргэнийг тодорхойлох аргачлал, шалгуур үзүүлэлтийг боловсруулах бэлтгэл ажлыг хангаж байна.

Эдийн засгийн хямралын нөхцөл байдалтай уялдуулан нийгмийн халамж болон хүн амын хөгжлийг хангах, өсөлтийг нэмэгдүүлэх, олгож буй мөнгөн тусламж, дэмжлэгүүдийг хэрхэн зохистой хуваарилах хувилбар боловсруулж, холбогдох тооцоо судалгааг хийв. Тухайлбал, хүүхдийн мөнгөн тэтгэмж, хүүхдийн хөгжлийн мөнгийг нийгмийн эмзэг бүлгийн буюу зорилтот бүлгийн хүүхдүүдэд чиглүүлэх тооцоо судалгаа хийж, Засгийн газарт хүргүүлэв.

Эх, хүүхдэд тэтгэмж олгох, хүүхэд, эх, гэр бүлд мөнгөн тусламж үзүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, танилцуулга, үзэл баримтлалыг боловсруулж, холбогдох судалгаа, тооцоог Сангийн яаманд хүргүүлэв.

“Монгол Улсыг хөгжүүлэх сангаас хүүхэд бүрт олгож буй хүүхдийн хөгжлийн мөнгийг өөрчлөх тухай” болон “Шинээр гэрлэгсдэд нэг удаа олгох мөнгөн тусламжийн хэмжээг өөрчлөх тухай” тогтоолын төсөл, танилцуулга, судалгаа, холбогдох тооцоог боловсруулан, Сангийн яаманд хүргүүлж, Засгийн газар, УИХ-д өргөн барив.

“Өрхийн хөгжлийн үндэсний хөтөлбөр”-ийг боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, өрх, иргэдийн амьжиргааны түвшинг тодорхойлох аргачлалыг боловсронгуй болгох зорилгоор сумын төвийн өрхүүдийн ерөнхий хэв шинжийг тодорхойлон гаргав.

Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар техникийн болон салбар дундын ажлын хэсгийн хурлыг зохион байгуулав. Мөн Монголын ажил олгогч эздийн нэгдсэн холбоо, Монголын үйлдвэрчний эвлэлийн нэгдсэн холбоо, ХЗДХЯ-ны салбар дундын ажлын хэсгийн гишүүдээс урьдчилсан байдлаар хуулинд тусгах саналуудыг авч, судалгаа тооцоог хийж байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал, Нийгмийн даатгалын сангаас Ажилгүйдлийн тэтгэмж олгох тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, санал авахаар холбогдох яам, газарт хүргүүлэв.

Хүн амын хөгжлийг дэмжих бодлогын хэрэгжилтийн хүрээнд. Тэнэмэл амьдралтай гудамж, орц траншейгээр байнга тэнүүчлэн амьдардаг 50 гаруй хүүхдийг дулаан орон байранд өвөлжүүлэх, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулан зохих эмчилгээ, сувилгаа хийх, бичиг баримтжуулах, нийгэмшүүлэх, сэтгэл засал, амьдралын итгэл үнэмшил олгох сургалтад хамруулах ажлыг зохион байгуулав.

Хүн худалдах ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүдийг бэлгийн мөлжлөгийн зорилгоор ашиглахаас хамгаалах Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих Зөвлөлийн хурлыг зохион байгуулж, “Хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох”, “Хохирогчдод зөвлөгөө өгөх үйлчилгээ үзүүлэх”, “Урьдчилан сэргийлэх”, “Мэдээллийн сан байгуулах” гэсэн дэд ажлын хэсгүүдтэй ажиллахаар төлөвлөв.

Төрийн зарим үйлчилгээг төрийн бус байгууллага /ТББ/-гаар гэрээлэн гүйцэтгүүлэх журмын төслийг боловсруулав. Журмын хүрээнд Засгийн газрын тухай хуулийн 19.1-ийн “Төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг бусад байгууллагад хариуцуулан гүйцэтгүүлэх” гэсэн заалтыг үндэслэн салбарын хэмжээнд ТББ-аар ажил үйлчилгээ гүйцэтгүүлэхэд тавигдах нийтлэг шаардлага, санхүүжүүлэх журам, үйл ажиллагааны үндсэн зарчмыг тогтоох, гэрээний явц, биелэлтийг үнэлж дүгнэхтэй холбогдолтой харилцааг зохицуулна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах бодлогын хэрэгжилтийн хүрээнд. 2009 онд Гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тогтоох тухай

Засгийн газрын тогтоолын төсөл, Ажиллах хүч гадаадад илгээж байгаа байдал болон дэлхийн эдийн засгийн уналттай холбогдуулан иргэдэд учирч буй хүндрэл бэрхшээлийн талаар танилцуулгыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэв.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайдын дэргэд Гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрөл олгох асуудлаар санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг шинэчлэн батлуулж, ажлын хэсэг хүсэлт ирүүлсэн компаниудын бичиг баримтыг судалж, дүгнэлт гаргахаар ажиллаж байна

Архангай аймгийн Засаг даргын тамгын газар, ҮЭ-ийн холбоо, ажил олгогч эздийн холбооны 2009-2010 оны гурван талт хамтын ажиллагааны хэлэлцээрийг хянан, Хөдөлмөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн дагуу бүртгэв.

“Малчдын аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”-ийн үр дүнг тооцох зорилгоор Өвөрхангай, Төв, Хэнтий аймгийн 7 сумын 20 гаруй өрхийн хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай танилцаж, холбогдох аймаг, сумын төсөл хэрэгжүүлэгч байгууллага, ажилтнуудтай төслийн үр дүнгийн талаар уулзалт, ярилцлага зохион байгууллаа.

Нийгмийн хамгааллыг сайжруулах бодлогын хэрэгжилтийн хүрээнд. Нийгмийн даатгалын байгууллагуудын удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж, аймаг, хот, нийслэл дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн удирдах ажилтнууд оролцон нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө, нийгмийн даатгалын хуулийн хэрэгжилтийг хангуулах, үйл ажиллагааны явцын талаар зөвлөлдөв.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын хамтарсан “Нийгмийн ажилтны талаар авах зарим арга хэмжээний тухай” тушаалын төслийг боловсруулж Хууль зүй, дотоод хэргийн яамнаас санал авахаар, хүргүүлэв.

“Ахмад настны нийгмийн хамгааллын тухай” хуульд нэмэлт, өөрчлөлт орсонтой уялдуулан “Тусламжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын дагуу дайнд оролцсон ахмад дайчдад сар бүр олгох мөнгөн тусламжийн хэмжээг 200000 төгрөгөөр тогтоож, мөнгөн тусламжийг цагаан сарын шинийн 1-ний өмнө олгоод байна.

“Дайнд оролцсон ахмад дайчинд орон сууц, түүнтэй дүйцэхүйц хэмжээний мөнгөн тусламж олгох журам”-ын хэрэгжилтийн талаархи мэдээллийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд, өмнө нь улсаас үнэ төлбөргүй байр авч байсан ахмад дайчдыг орон сууц, эсхүл мөнгөн тусламжид хамруулахгүй байхаар шийдвэрлэв.

Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди сар шинийн өмнө хоёр дайнд оролцож явсан ахмад дайчин Ж.Лувсандэндэв, Д.Батаа, С.Борхүү нарт орон сууцны түлхүүр болон мөнгөн тусламж гардууллаа. Энэ удаагийн арга хэмжээнд хоёр дайнд оролцож явсан 44 ахмад дайчинд орон сууц, мөнгөн тусламж өглөө. 2009 онд нийт 90 гаруй ахмад дайчны орон сууцны асуудлыг шийдвэрлэхээр төлөвлөж байна.

### Хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдал

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтэсүүдэд ажил идэвхитэй хайж бүртгүүлсэн ажилгүй иргэдийн тоо 32.3 мянга, ажилгүйдлийн түвшин 3.1 хувьтай болсон нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад ажилгүй иргэдийн тоо 1757 хүнээр буюу 5.8 пунктээр, ажилгүйдлийн түвшин 0.2 пунктээр нэмэгдсэн байна. Тайлангийн хугацаанд ажил олгогчдоос нийт 2267 ажлын байрны захиалга ирүүлснээс тэдгээрт 1932 иргэнийг ажилд зуучлан оруулж, 618 ажилгүй иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулав.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээний хүрээнд Засгийн газрын 2006 оны 166 дугаар тогтоолоор батлагдсан “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох зээлийн хүү нөхөн төлөх журам”-ын дагуу банк, банк бус санхүүгийн байгууллагуудаар дамжуулан жижиг зээл олгож байна. 2009 оны 1 сарын байдлаар Хас, Монгол Шуудан, Капитал, ХААН банкууд, Актив Инвест, Ажилгүйдлийг Бууруулахад Туслах сан, Капмон, банк бус санхүүгийн байгууллагуудаар дамжуулан 272 албан бус хөдөлмөр эрхлэгч, 438 ажилгүй иргэн, 184 малчин, 30 аж ахуйн нэгж, байгууллагад 1 тэрбум 318.2 сая төгрөгийн зээлийг олгосноор 1918 хүн ажлын байраар хангагдаад байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд нийт 219980.2 мянган төгрөгийн хөрөнгө төвлөрүүлж 23012.9 мянган төгрөг зарцуулсан байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ. Үүнд:

\*Ажилд зуучлахад нийт зарцуулсан хөрөнгийн 2.3 хувь буюу 528.5 мянган төгрөгийг зарцуулж 358 иргэнийг,

\*Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангахад нийт зарцуулсан хөрөнгийн 11.0 хувь буюу 2528.8 мянган төгрөгийг зарцуулж 380 иргэнийг,

\*Мэргэжил олгох давтан сургалтад хамруулахад нийт зарцуулсан хөрөнгийн 22.7 хувь буюу 5230.0 мянган төгрөгийг зарцуулж нийт 55 иргэнийг тус тус хамруулсан байна.

\*Нийтийг хамарсан ажил зохион байгуулахад нийт зарцуулсан хөрөнгийн 1.2 хувь буюу 281.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

\*Ажил олгогчийг дэмжихэд нийт зарцуулсан хөрөнгийн 38.6 хувь буюу 8875.1 мянган төгрөгийг зарцуулж 15 иргэнийг хамруулсан байна.

\*Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсүүдийн материаллаг баазыг бэхжүүлэхэд нийт хөрөнгийн 0.9 хувь буюу 198.3 мянган төгрөгийг,

\*Хөдөлмөрийн зах заалийн мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох арга хэмжээнд нийт хөрөнгийн 15.6 хувь буюу 3583.0 мянган төгрөгийг тус тус зарцуулав.

### **Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарт:**

*Боловсрол.* Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг УИХ-ын 2009 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн нэгдсэн чуулганаар баталлаа.

Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд мэргэжлийн боловсрол, сургалтын талаар төр, засгийн бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг нэгдсэн зохицуулалтаар хангах үүрэгтэй төрийн захиргааны байгууллага-Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байгуулахаар заасан. Үүний дагуу Мэргэжлийн боловсрол, сургалтын газрын орон тоо, бүтэц, чиг үүргийн батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд, хуралдаанаас төслийг УИХ-д өргөн барихаар шийдвэрлэв.

Сургалтын төрийн сангаас дотоодын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургууль, коллежоос суралцагчдын хамрагдах мэргэжлийн чиглэл, хуваарийн төслийг боловсруулж, Засгийн газрын 2 сарын 4-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлээ.

Дээд боловсролын шинэчлэлийн асуудлаарх 3 дахь удаагийн уулзалт, хэлэлцүүлгийг зохион байгуулж, дээд боловсролыг шинэчлэх үйл ажиллагааны чиглэл, “Их сургуулийн эрх зүйн байдлын тухай” хуулийн үзэл баримтлал, их сургуулийг хотхон хэлбэрээр хөгжүүлэх үзэл баримтлал гэсэн сэдвүүдийн хүрээнд хэлэлцүүлэг явууллаа. Уулзалтын явцад гарсан санал, дүгнэлтэд тулгуурлан дээд боловсролын шинэчлэлийн үзэл баримтлалын төслийг боловсруулж байна.

Монгол Улсад сурч буй гадаад оюутнуудтай уулзалт зохион байгууллаа. Өнөөдрийн байдлаар манай улсад гадаадын 27 улсаас 1200 гаруй оюутан 51 их, дээд суралцаж байгаагийн 170 оюутан нь хоёр улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн дагуу суралцагч, үлдсэн нь хувиараа суралцагч байна. Уулзалтын үр дүнд гадаад оюутнуудын нийгмийн хамгаалал, суралцах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр цаашид авах арга хэмжээний чиглэлийг тодорхойллоо.

“Нийтийн биеийн тамир, спортын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2009 оны 5 дугаар тогтоолын дагуу БСШУ-ы сайдын “Биеийн тамир, спортын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2009 оны 36 дугаар тушаал гаргалаа. Энэхүү тушаалаар хоёрдугаар сарыг салбарын хүрээнд “Бие бялдарын соёл, боловсролыг дэмжих” аяны сар болгож, бүх шатны сургуулийг хамарсан спортын арга хэмжээ зохион байгууллаа.

Сарын аяны нээлтийн үеэр Спортын төв ордны материаллаг баазыг түшиглэн байгуулсан спортын сургалттай дунд сургуулийг албан ёсоор нээлээ. Уг сургуулиар дамжуулан эрүүл чийрэг бие бялдартай иргэдийг өсгөх, биеийн тамир, спортын чиглэлээр хичээллэгчдийн авъяас, чадварыг тусгай хөтөлбөрийн дагуу хөгжүүлэх үндэс суурь тавигдаж байна. Сургуульд жудо бөх, бокс, чөлөөт бөх, буудлага, спортын болон уран сайхны

гимнастик, хөнгөн атлетик, сагсан бөмбөг, гар бөмбөг, хөл бөмбөг, цана, тэшүүр, ширээн теннис, шатар, даам зэрэг спортын 15 төрлөөр, дунд ангиас нь эхлэн тодорхой шалгуурын дагуу сурагчдыг элсүүлэн авч, 200-аад хүүхэдтэй хичээллэж байна.

БСШУ-ы сайдын “Багшийн хөгжлийн танхим ажиллуулах зөвлөмж батлах тухай” 2008 оны 114 дүгээр тушаалын хэрэгжүүлэх зорилгоор 2008-2009 оны хичээлийн жилд аймаг, нийслэлийн 50 сургуульд багшийн хөгжлийн танхимын тавилга, тоног төхөөрөмж, 30 сургуулийн цайны газарт гал тогооны тоног төхөөрөмж нийлүүлэх ажлыг эхлүүлээ.

БСШУ-ы сайдын 2009 оны 48 дугаар тушаалаар ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг болон албан бус боловсролын багшид “Зөвлөх багш” мэргэжлийн зэрэг олгох талаар дүгнэлт гаргах бүхий ажлын хэсгийг байгуулж, нийт 52 хүний материалтай танилцаж, БСШУ-ы сайдын 2009 оны 59 дүгээр тушаалаар 38 багшид зөвлөх зэрэг олголоо.

“Бага насны хүүхдийг хөгжүүлэх арга зүй” сэдэвт үндэсний сургагч багш бэлтгэх сургалтыг Япон улсын Жайка олон улсын байгууллагын санхүүжилтээр 2009 оны 2 дугаар сарын 6-10-ний өдрүүдэд зохион байгуулав.

*Соёл урлаг.* “Монгол төрийн түүхийн музей байгуулах тухай” Засгийн газрын 2009 оны 30 дугаар тогтоолоор Чингис хааны дурсгалын хөшөө, төрийн ёслол хүндэтгэлийн өргөө цогцолборыг ашиглалтад хүлээн авсантай холбогдуулан Монгол төрийн түүхийн музейг Үндэсний музейн харъяанд байгуулан ажиллуулахаар шийдвэрлүүлээ.

Нийслэл Улаанбаатар хот үүсч байгуулагдсаны 370 жилийн ойг 2009 оны 10 дугаар сарын 29-ний өдөр тэмдэглэн өнгөрүүлэх тухай асуудлыг Засгийн газрын 2 дугаар сарын 4-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэж баталлаа.

БН Халимаг Улсын соёлын өдрүүдийг 1 дүгээр сарын 31-ээс 2 дугаар сарын 4 хүртэл зохион байгуулж, энэ үеэр хоёр улсын уран бүтээлчдийн хамтарсан урлагийн тоглолт, “Цагаан сарын домог” драмын жүжиг, уулзалт-ярилцлага, фото зургийн үзэсгэлэн зэрэг арга хэмжээнүүд явагдлаа.

Үндэсний соёл, угсаатны онцлог, зан заншлыг илэрхийлсэн “Монгол бэлэг” үзэсгэлэн-уралдааныг дүгнэх ажлыг зохион байгуулж, уралдаанд ирүүлсэн бүтээлүүдээр үзэсгэлэн-худалдаа гаргаж, тусгайлан зарласан номинацийн дагуу 12 төрлийн шилдэг бүтээлийг шалгарууллаа.

Оны шилдэг уран бүтээл, уран бүтээлч шалгаруулах ёслолын арга хэмжээг зохион байгуулж, шилдэг уран бүтээл, бүтээлчдэд шагнал олгох, хүүхдэд зориулсан уран бүтээлийн улсын 2 дугаар уралдаанд шалгарсан бүтээлчдэд цом, мөнгөн урамшуулал гардуулж, хүндэтгэлийн тоглолт зохион байгууллаа. Монгол төрийн үндэсний их найралд 168,9 сая төгрөг бүхий хоёр дахь ээлжийн үндэсний хөгжмийг энэ үеэр олголоо.

АНУ-ын Хюстэн хотын байгалийн шинжлэх ухааны музейд “Чингис хаан” үзэсгэлэнг гаргаж, нээлтийн арга хэмжээг 2 дугаар сарын 25-ны өдөр зохион байгууллаа. Үзэсгэлэнд түүх, археологи, угсаатны зүйн чиглэлийн 156 үзмэрийг тавьсан бөгөөд үзэсгэлэн энэ оны 9 дүгээр сар хүртэл үргэлжилнэ.

Ном, хэвлэлийн 2008 оны шилдэг бүтээл шалгаруулах ажлыг зохион байгуулж, нийт 179 ном ирүүлснээс 55 номыг шилдгээр шалгаруулж, “Ном хэвлэлийн шилдэг бүтээлийг улсын санд худалдан авах тухай” БСШУ-ы сайдын 2009 оны 49 дүгээр тушаалаар эдгээр номыг улсын санд худалдан авлаа.

*Шинжлэх ухаан, технологи.* “Үндэсний инновацийн тогтолцоо ба мэдээллийн технологи” семинарыг Мэдээлэл, шуудан харилцаа холбоо, технологийн газар, Мэдээллийн технологийн үндэсний парктэй хамтран зохион байгуулав. Семинарт төрийн болон төрийн бус байгууллага, мэдээллийн технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа их, дээд сургууль, эрдэм шинжилгээний болон бизнесийн байгууллагуудыг төлөөлсөн 100 шахам төлөөлөгч оролцов. Оролцогч байгууллагуудаас мэдээллийн технологийн талаарх төрийн бодлого, түүний хэрэгжилт, салбарын хөгжлийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, цаашид авах арга хэмжээний талаар 9 илтгэл хэлэлцүүлж, төрийн болон төрийн бус байгууллага, их, дээд сургууль, эрдэмтэд, судлаачид, бизнес эрхлэгчдэд хандан зөвлөмж гаргалаа.

ШУА-ийн харъяа Байгалийн шинжлэлийн нэгдсэн лабораторид улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 700 сая төгрөгийн нарийн судалгааны багаж төхөөрөмж шинээр нийлүүлсэн бөгөөд нээлтийн ажиллагааг 2009 оны 2 дугаар сарын 8-нд хийж, энэ үеэр “Байгалийн шинжлэлийн нэгдсэн лаборатори-2009” семинар зохион байгуулав. Семинарт физик, хими, анагаах, геологи, биологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг их сургууль, эрдэм шинжилгээний байгууллагын төлөөлөл оролцов. Семинарын үеэр багаж, төхөөрөмжийн үйл ажиллагаа, хэрэглэх нөхцөл боломж, хамтын ажиллагааны талаар зөвлөлдөв.

Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн ерөнхий менежерүүдийн Төсвийн ерөнхийлөн захирагчтай 2009 онд бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээг байгууллаа.

### **Эрүүл мэндийн салбарт:**

Хүн амын эрүүл мэндийг хамгаалах талаар авсан арга хэмжээ, үр дүнгийн үнэлгээ. Эрүүл мэндийн сайдын 2009 оны 34 дүгээр тушаалаар ЭМД-ын сангаас санхүүжилт авах хувийн хэвшлийн эмнэлгүүдийн сонгон шалгаруулалтад хамрагдах тусламж үйлчилгээний төрөл, хамрах хүрээ, хугацаа, эрүүл мэндийн байгууллагад тавих шалгуур үзүүлэлт, үнэлэх аргачилал, сонгон шалгаруулалтын урилгын загварыг баталж, 2010 онд ЭМД-ын сангаас санхүүжилт авах хувийн хэвшлийн эмнэлгийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг 2009 оны 4 дүгээр сарын 01-ний дотор зохион байгуулж дүгнэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга, Эрүүл мэндийн газарт даалгалаа.

Эрүүл мэндийн сайдын 2009 оны 39, 46 дугаар тушаалуудаар багц цаг биелүүлсэн 96, мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн шалгалтанд тэнцсэн 74, гадаадын харьяат 5 эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хавсралтад заасан хугацаагаар тус тус олгохоор шийдвэрлэв.

Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 28/40/29 тоот хамтарсан тушаалаар “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”, “Химийн хорт болон аюултай бодисын эрсдэлийн үнэлгээ хийх журам”-ыг тус тус баталж, журмыг аймаг, нийслэлд хүргүүлэх, сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахыг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгов.

Эрүүл мэндийн сайдын 2009 оны 41 дүгээр тушаалаар “Эмнэлгийн мэргэжилтнүүдийн хандлага, харилцааны үр чадварын”, “БЗДХ/ХДХВ/ДОХ-ын мэргэжлийн”, “Цус сэлбэлт, судлалын салбар зөвлөл, түүний бүрэлдэхүүнийг нэмж, “Мэдрэлийн мэргэжлийн салбар зөвлөл”, “Сувилахуйн мэргэжлийн салбар зөвлөл”-үүдийн бүрэлдэхүүнийг тус тус шинэчлэн батлав.

Эрүүл мэндийн сайдын 2009 оны 51 дүгээр тушаалаар Төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг улсын хэмжээнд үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын хуваарь, үндсэн мэргэжлийн эмнэлгийн тусламж, үйлчилгээг нийслэлд үзүүлэх эрүүл мэндийн байгууллагуудын хуваарийг тус тус баталж, хуваарийн дагуу тусламж, үйлчилгээ үзүүлэх ажлыг шуурхай зохион байгуулахыг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгов.

Эрүүл мэндийн сайдын 2009 оны 52 дугаар тушаалаар Дэлхийн зөн байгууллагын Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрүүдийн санхүүжилтээр олгогдож буй эмнэлгийн түргэн тусламжийн зориулалтын Тоёото Ланд-крузер маркийн 8 автомашиныг Булган, Баян-Өлгий, Баянхонгор, Өвөрхангай аймгийн нэгдсэн эмнэлэг, ЭМЯ-ны алсын түргэн тусламжийн төв, нийслэлийн яаралтай тусламжийн төв, Налайх дүүргийн Эрүүл мэндийн төвд тус тус олголоо.

Эрүүл мэндийн яам болон “М Си Эс Электроникс” ХХК-ийн хооронд байгуулсан СТП-2008 гэрээг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2009 оны 54 дүгээр тушаалаар гэрээний дагуу худалдан авсан 56,8 сая төгрөгийн үнэ бүхий эмнэлгийн тоног төхөөрөмжийг яамны харьяа клиникийн эмнэлэг, төвүүдэд болон нийслэлийн эрүүл мэндийн газарт хуваарилан олголоо.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авах арга хэмжээнд хийсэн үнэлгээ. Дархлаажуулалтын тухай хуулийн 3 дугаар бүлгийн 11.1, Засгийн газрын 2007 оны 61 дүгээр тогтоолын холбогдох заалтыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын 2009 оны 55 дугаар тушаалаар хүний томуугийн 28000 хүн/тун вакциныг бүх аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт хуваарилж, хэрэглэх зааврыг баталжээ. Мөн хуваарилсан вакцинаар аймаг, нийслэлийн хил,

гааль, мэргэжлийн хяналт, онцгой байдал, эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтэн байцаагч зэрэг эрсдэл бүхий бүлгийн хүн амыг тархвар судлалын заалтаар дархлаажуулах арга хэмжээг энэ оны 3 дугаар сарын 20-ны дотор багтаан зохион байгуулахыг ХӨСҮТ-ийн захирал, аймаг нийслэлийн ЭМГ-ын дарга нарт даалгаж, дархлаажуулалтын тайлан мэдээг энэ оны 4 дүгээр сарын 15-ны дотор гаргаж ЭМЯ-нд ирүүлэхийг ХӨСҮТ-ийн захиралд даалгав.

Нэн шаардлагатай эмийн хангамжийн мэдээ. 2009 оны 2 дугаар сарын 24-ний байдлаар эм хангамжийн салбарт зонхилох байр суурь эзэлдэг “Монголэмимпекс” ХХК, “Монофармтрейд” ХХК, “Еврофарм” ХХК, “Азифарм” ХХК-аас ирүүлсэн зайлшгүй шаардлагатай эмийн үлдэгдэлийн мэдээгээр хот, хөдөөд 199 нэрийн нийт 3.5 тэрбум төгрөгийн үндэсний зайлшгүй шаардлагатай эм /ҮЗШЭ/-ийн үлдэгдэлтэй байна.

Энэ сард эм ханган нийлүүлэх байгууллагууд 75 удаагийн өргөдлөөр 230 нэрийн эм, 97 нэрийн эмнэлгийн хэрэгсэл, 351 нэрийн оношлуур урвалж, 19 нэрийн вакцин өсгөөрт лиценц авч импортлоод байна.

Цочмог халдварт өвчний өвчлөл, нас баралт, эх, хүүхдийн эндэгдлийн мэдээ, үнэлгээ. 2009 оны эхний сарын байдлаар улсын хэмжээнд нийт 5379 эх амаржиж 5398 амьд хүүхэд төрж өнгөрсөн оныхоос төрсөн эх 289-өөр, амьд төрсөн хүүхдийн тоо 815-аар тус тус нэмэгдсэн байна. Энэ сард 4 эх эндэсний 2 нь Улаанбаатар хотод, аймгуудаас Говь-Алтай, Өвөрхангайд тус бүр нэг эх эндсэн байна. Эхийн эндэгдэл өнгөрсөн оныхоос 100000 амьд төрөлтөнд 54.6-аар нэмэгдсэн байна (100000 амьд төрөлтөнд 74,1 байна).

0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 119 тохиолдол бүртгэгдэж өмнөх оныхоос 23-аар, 1000 амьд төрөлтөнд 1,2 пунктээр тус тус нэмэгдсэн, Өмнөговь 7(72,9), Хэнтий 5(36.8), Баянхонгор 6(32.6), Говьсүмбэр 1(30.3), аймагт улсын дундаж /22,0/-аас өндөр байна.

1-5 хүртэлх насны 18 хүүхэд эндсэн нь өмнөх оныхоос 4-өөр буурсан боловч, амьд төрсөн 1000 хүүхдэд 25,4 байгаа нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 1,3 пунктээр тус тус нэмэгдсэн байна.

2009 оны эхний сард 2965 халдварт өвчин бүртгэгдсэн нь урьд оныхоос 890 тохиолдлоор буурсан, 10000 хүн амд 14,8 ногдож байна.

Бүртгэгдсэн халдварт өвчний дотор цусан суулга, хүнснээс гаралтай бактерт хордлого, бруцеллез, тэмбүү, гонококк халдвар, гахай хавдар, улаанбурхан, ДОХ/ХДХВ, зэрэг өвчний тохиолдлын тоо өнгөрсөн оны мөн үеийнхээс нэмэгдсэн байна.

Халдварт өвчний бүтцийн хувьд авч үзвэл зонхилон тохиолдох бэлгийн замын халдварт өвчин 41,8%, гэдэсний халдварт өвчнүүдээс вирус гепатит 26,7%, амьсгалын замын халдварт өвчнөөс сүрьеэ 9,3%, салхин цэцэг 7,6%, гахай хавдар 2.4%-ийг тус тус эзэлж байна.

Өргөн дархлаажуулалт бүхий халдварт өвчнүүдээс халдварт саа, сахуу, хөхүүл ханиад зэрэг өвчний тохиолдол бүртгэгдээгүй байна.

Энэ сард халдварт өвчний улмаас 9 хүн нас барсанаас сүрьеэгээр 7, вирус гепатит, татрангийн улмаас тус бүр нэг хүн нас барсан байна.

### **Санхүү, эдийн засгийн салбарт:**

Монгол Улсын төсвийн орлогын 2009 оны 1 дүгээр сарын урьдчилсан гүйцэтгэл, төсвийн хөрөнгө оруулалтын талаар авах арга хэмжээний тухай Сангийн сайд Засгийн газрын (2009 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн) хуралдааны үеэр Засгийн газрын гишүүдэд танилцууллаа. Үүнтэй холбогдуулан (1) улсын төсвийн орлого буурч байгаатай холбогдуулан төсвийн урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг тодорхой хэмжээгээр бууруулах талаар саналаа боловсруулан Сангийн яаманд яаралтай ирүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт; (2) улсын төсвийн орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх, төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэрийн дутагдлыг нөхөх талаар бололцоотой арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг Сангийн сайдад; (3) Улсын төсвийн болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2009 онд шинээр эхлэн хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн ажлын гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үйл ажиллагааг түр хугацаагаар хойшлуулахыг Сангийн сайд, төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус үүрэг болгов.

Санхүү, эдийн засгийн болзошгүй хямралаас урьдчилан сэргийлэх цогц бодлого, арга хэмжээний төлөвлөгөөний тухай Засгийн газрын (2009 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцэж, энэхүү төлөвлөгөөний төсөлд Засгийн газрын гишүүдийн гаргасан саналыг тусгаж, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтлоо. Энэхүү төлөвлөгөөний **үндсэн зорилго нь** Монгол Улсын 2009 оны эдийн засгийн өсөлтийг 4-5 хувиас бууруулахгүй байх; Санхүү, эдийн засгийн хямралын үр дагавраас иргэдэд учрах хохирол, сөрөг нөлөөллийг багасгах, ажлын байрыг хадгалах, ажилгүйдлээс сэргийлэх; Санхүүгийн тогтвортой байдлыг хангахад чиглэгдэж байна.

**Төлөвлөгөөний хүрээнд:** (1) улсын төсвийн зарлагын тогтолцоог эргэн харж нягтлах, үргүй зардлуудаас салах, төсвийн тодотголыг бодит төвшинд хийх, төрийн байгууллагын бүх төвшинд хэмнэлтийн горимд шилжих; (2) банк, санхүүгийн салбарын найдвартай үйл ажиллагааг бий болгох замаар бодит эдийн засгийн салбарыг дэмжих; (3) нийтийг хамарсан хөдөлмөр эрхлэлтийн төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх; (4) эрчим хүч, дулааны найдвартай байдал, хангамжийг сайжруулах; (5) Зуун мянган айлын орон сууц, Улаанбаатар хотын авто замыг сайжруулах, “Хоёр толгой”-н ашиглалт, түүнийг дагалдсан дэд бүтцийн төслүүдээр дамжуулан шинэ ажлын байр бий болгох; (6) өрхийн орлогогүй, эмзэг хэсэгт халамж үзүүлэх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 2009 оны эхний хагас жилд 740.0 гаруй тэрбум төгрөгийн эх үүсвэр шаардлагатай гэсэн тооцоо гарсан бөгөөд үүнийг хүнсний хомсдол, банк, санхүү, ажилгүйдэл, эрчим хүчний хямралаас урьдчилан сэргийлэхэд чиглүүлэх юм.

Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын (2009 оны 2 дугаар сарын 16-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцэж, Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийгмийн даатгалын сангийн 2009 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, тэдгээртэй холбогдуулан бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслүүдэд Засгийн газрын гишүүдийн гаргасан саналыг тусган УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтсон байна. Энэхүү төсөлд төсвийн орлогын боломжит болон нэмэлт эх үүсвэрийг эрэлхийлэх, тэвчиж болох урсгал зардлыг бууруулах, эдийн засгийн өсөлтийг хангах, ажлын байр бий болгох зардлыг хэвээр хадгалах, төрийн албаны орон тоо, цалин хөлс, бусад зардлыг хэмнэлтийн горимд шилжүүлэх, нийгмийн халамжийн арга хэмжээг хэрэгцээтэй бүлэгт оновчтой чиглүүлэх замаар эмзэг бүлгийг хамгаалах, амин чухал бус болон шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөж буй хөрөнгө оруулалтыг хойшлуулах, зогсоох аргаар эх үүсвэрийг чөлөөлөхөд чиглэгдсэн ТӨСВИЙГ ТЭНЦВЭРЖҮҮЛЭХ БОДЛОГО баримталсан байна.

**Төсвийн урсгал зарлагыг бууруулах арга хэмжээний хүрээнд** 1) Улсын төсвөөс хүүхдэд сар бүр олгодог 3000 төгрөгийг үргэлжлүүлэн олгож, Монгол Улсыг хөгжүүлэх сангаас улирал тутам олгодог 25.000 төгрөгийг Монгол Улсыг хөгжүүлэх сангийн үлдэгдэлтэй уялдуулах; 2) Шинээр гэрлэгчдэд олгож буй 500.000 төгрөгийг 300.000 болгож, 6.6 тэрбум төгрөгөөр зардлыг бууруулах; 3) Шинээр төрсөн хүүхдэд олгох 100.000 төгрөг, Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгох мөнгөн тусламжийг үргэлжлүүлэн олгох; 4) Зарим төрлийн нийгмийн халамжийн тэтгэмжийн давхардлыг арилгах; 5) Төрийн нийт албан хаагчдын цалинг гуравдугаар сарын 1-нээс эхлэн нэг жилийн хугацаанд 20 хувиар, төрийн өндөр албан тушаалтны цалинг 30 хувиар (нийт 98.6 тэрбум төгрөгөөр) бууруулах; 6) Төсөвт байгууллагын бараа, үйлчилгээний зардлыг багасгаснаар 25.3 тэрбум төгрөг хэмнэх; 7) Орон тоог нэмэгдүүлэхгүй байх, орон тооны хязгаараас хэмнэгдэж байгаа, сул буй орон тоо, тэтгэвэрт гарч буй иргэний оронд шинээр ажилтан нэмж авахгүй байхаар тогтсон байна.

**Хөрөнгө оруулалтыг хумих арга хэмжээний хүрээнд** 2009 онд шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хойшлуулах; өмнөх онд барихаар төлөвлөгдөж 2009 онд шилжиж байгаа боловч тухайн төслийн тендер зарлагдаагүй, барилгын ажлын гэрээ байгуулагдаагүй, гэрээ байгуулсан хэдий ч барилга угсралтын ажил эхлээгүй, санхүүжилт хийгдээгүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг хойшлуулах зэрэг арга хэмжээ авснаар улсын төсвийн хөрөнгө оруулалт батлагдсанаас 130 гаруй тэрбум төгрөгөөр буурна гэж тооцсон байна.

Засгийн газрын бондын тухай Засгийн газрын (2009 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын 2009 оны 58 дугаар тогтоолоор Улсын Их Хурлын

2009 оны 8 дугаар тогтоолоор зөвшөөрсөн Засгийн газрын үнэт цаасыг 2009 оны төсвийн жилд багтаан Монгол банк болон банк, санхүүгийн бусад байгууллагад арилжаалахыг Сангийн сайдад зөвшөөрсөн байна. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 300 хүртэл тэрбум төгрөгийн бондыг төсвийн дотоод тэнцлийг хангах, зарлага санхүүжилтийн эх үүсвэрийн дутагдлыг нөхөхөд зориулан эхний ээлжинд 60.0 тэрбум төгрөгийн бондыг Монголбанкнд арилжиж, үлдэх бондыг бусад банк, санхүүгийн байгууллага болон нийтэд арилжаалахаар төлөвлөсөн байна.

Банкин дахь хадгаламжид баталгаа гаргах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын (2009 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцэж, хулийн төслийг Улсын Их Хуралд 2009 оны 2 дугаар сарын 19-ны өдөр өргөн мэдүүлэв. Банк, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа арилжааны банкин дахь иргэдийн мөнгөн хадгаламжид төрөөс баталгаа гаргасан билээ. Хууль батлагдсанаас хойшхи хугацаанд хадгаламжийн хэмжээ 15.2 тэрбум төгрөгөөр буюу 1 хувиар өссөн хэдий ч харилцах дансны үлдэгдэл 29.6 тэрбум төгрөгөөр буюу 4.6 хувиар буурсан нь банкин дахь харилцахад төрөөс баталгаа гаргаж, мөнгөний гадагшлах урсгалыг зогсоох зайлшгүй шаардлагатай болсныг харуулж байна. Үүнтэй холбогдуулан “Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах замаар банкин дахь иргэний ба хуулийн этгээдийн харилцах дансны үлдэгдлийг баталгаанд нэгэн адил хамааруулахаар тооцож эл хуулийн төсөл боловсруулсан байна.

Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын (2009 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн) хуралдаанаар хэлэлцэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсоны дагуу хуулийн төслийг Улсын Их Хурлын даргад 2009 оны 2 дугаар сарын 19-ний өдөр өргөн барьсан байна. Дэлхийн санхүүгийн хямралын үр дагавраас шалтгаалан ам.долларын төгрөгтэй харьцах ханш огцом өссөн явдал өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийг хөөрөгдөж, хэрэглэгчдийн худалдан авах чадварт муугаар нөлөөлж байна. Үүнтэй уялдуулан ам.долларын ханшны өсөлтийг хязгаарлах, төгрөгийн ханшийн уналтыг зогсоох, татвар төлөгчдийн ханшны зөрүүгээс үүсэх алдагдлыг бууруулах, улмаар бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийг тогтворжуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Татварын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.8 дахь хэсэгт “Монгол Улсын татварыг Монгол Улсын мөнгөн тэмдэгт төгрөгөөр ногдуулж төлөх”өөр тусгасан байна. Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулсантай холбогдуулан Онцгой албан татварын тухай, Тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан байна. аливаа төлбөр тооцоог төгрөгөөр гүйцэтгэж, ам.доллароор ногдуулж байсан аливаа татварыг төгрөгөөр тооцож авдаг байхаар хуулийн төсөлд тусгасан байна.

Ерөнхий сайдын 2008 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 57 дугаар захирамжаар байгуулсан Төлбөрийн тэнцэл, гадаад худалдааны статистик мэдээллийн чанарыг сайжруулах аргачлал, эрхзүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, гадаад худалдааны статистик мэдээлэлд гарсан зарим алдааг залруулах үүрэг бүхий ажлын хэсгийн гадаад худалдааны барааны статистик үзүүлэлтийг тооцох аргачлал болон 1997-2008 оны гадаад худалдааны тэнцэлд гарсан зарим алдааг залруулсан тухай Сангийн сайд Засгийн газрын (2009 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн) хуралдааны үеэр Засгийн газрын гишүүдэд танилцуулсан байна.

Улсын Их Хурлын 2009 оны 8 дугаар тогтоолыг үндэслэн Сангийн сайдын (2009 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн 27 дугаар) тушаалаар Засгийн газрын 300.0 тэрбум төгрөгийн үнэт цаасны 2009 оны арилжааны хуваарийг баталлаа. Засгийн газрын үнэт цаасыг 4-6 дугаар саруудад 91-728 хоногийн хугацаатай, 7-12 дугаар саруудад 182-364 хоногийн хугацаатай, жишиг хүүгийн хэмжээг 9.95 хүртэл хувь байхаар тогтоосон байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2009 оны нэгдүгээр сарын гүйцэтгэлийн мэдээг нэгтгэн гаргаж, удирдлага болон олон нийтэд мэдээллээ:

(1) Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого 2009 оны 1 дүгээр сарын гүйцэтгэлээр **83.8** тэрбум төгрөгт хүрч, орлогын төлөвлөгөөг **14.4** тэрбум төгрөгөөр буюу 14.7 хувиар тасарч, харин 2008 оны мөн үеийнхээс 91.7 тэрбум төгрөгөөр буюу 52.2 хувиар буурсан байна. Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогыг эх үүсвэрээр нь задалж үзвэл татварын орлогоор 91.0 хувийг, татварын бус орлогоор 8.9 хувийг, хөрөнгийн ба тусламжийн орлогоор 0.1 хувийг бүрдүүлсэн байна. Нэгдсэн төсвийн орлогын төлөвлөгөө тасрахад орлогын албан татварын



орлого 19.8 хувиар буюу 2.3 тэрбум төгрөгөөр, гадаад худалдааны орлого 38.0 хувиар буюу 4.5 тэрбум төгрөгөөр, татварын бус орлого 48.4 хувиар буюу 7.0 тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелсэн явдал голлон нөлөөлсөн байна.

(2) Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага 2009 оны 1 дүгээр сарын батлагдсан төлөвлөгөөгөөр 165.3 тэрбум төгрөг (үүнээс: улсын төсвийн зарлага 144.5 тэрбум төгрөг) зарцуулахаас гүйцэтгэлээр **112.5** тэрбум төгрөг (улсын төсвийн зарлага **97.0** тэрбум төгрөг)-т хүрч, төлөвлөсөн нэгдсэн төсвийн зарлагын 68.0 хувийг (улсын төсвийн зарлагын 67.1 хувийг) санхүүжүүлсэн бөгөөд өнгөрсөн 2008 оны мөн үеийнхээс нэгдсэн төсвийн зарлага санхүүжилт 24.5 тэрбум төгрөгөөр буюу 17.9 хувиар (улсын төсвийн зарлага 2008 оны мөн үеийнхээс 19.0 тэрбум төгрөгөөр буюу 16.4 хувиар) буурсан байна. Монгол Улсын төсвөөс 2009 оны нэгдүгээр сарын гүйцэтгэлээр цалин, тэтгэвэр, тэтгэмжийг бүрэн тавьж олгосон бөгөөд халамжийн сангаас хүүхдийн мөнгө хөтөлбөрт 2.1 тэрбум төгрөг, шинээр төрсөн хүүхдийн мөнгөн тусламжид 0.4 тэрбум төгрөг, шинэ гэр бүлд олгох мөнгөн тусламжид 0.9 тэрбум төгрөг, жирэмсэн ба нярай эхчүүдийн тэтгэмжид 1.2 тэрбум төгрөг, алдар цолтой ахмад настанд олгох нэмэгдэлд 0.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Улсын нэгдсэн төсвийн урсгал зардлын 10.3 хувийг буюу 10.6 тэрбум төгрөгийг нийгмийн халамжийн сангийн зардалд, цалин, нийгмийн даатгалын шимтгэлд 43.0 хувийг буюу 41.3 тэрбум төгрөгийг, өөрөөр хэлбэл, нийт урсгал зардлын 53.3 хувийг буюу 52.2 тэрбум төгрөгийг цалин, тэтгэвэр, тэтгэмжид зарцуулсан байна.

(3) Орон нутаг 2009 оны нэгдүгээр сарын гүйцэтгэлээр төсвийн орлогын төлөвлөгөөг 15.8 хувиар буюу **2.3** тэрбум төгрөгөөр тасалж, төсвийн зарлагын 57.2 хувийг буюу 6.1 тэрбум төгрөгийг дутуу санхүүжүүлсэн байна. Улсын төсөвт орон нутгаас 3.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэхээс **1.9** тэрбум төгрөгийг оруулж, харин улсын төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөг Дархан-Уул, Сэлэнгэ, Өмнөговь аймаг, Улаанбаатар хот 0.1-1.5 тэрбум төгрөгөөр тасалдуулсан байна.

(4) Монгол Улсыг хөгжүүлэх сангийн 2008 оны үлдэгдлээс эхний сард 0-18 насны хүүхэд бүрт олгох сарын 3000 төгрөгийн мөнгөн тэтгэмжид 2.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

(5) Монгол Улсын нэгдсэн төсвийн (өссөн дүнгээр) 2009 оны нэгдүгээр сарын гүйцэтгэлээр урсгал тэнцэл **18.7** тэрбум төгрөгийн, нийт тэнцэл **28.7** тэрбум төгрөгийн алдагдалтай (үүнээс: улсын төсвийн урсгал тэнцэл 26.0 тэрбум төгрөгийн, нийт тэнцэл 31.4 тэрбум төгрөгийн алдагдалтай) гарсан байна. Засгийн газар төсвийн алдагдлыг хэрхэн санхүүжүүлэх эх үүсвэрийг судлан олон улсын санхүүгийн байгууллагатай харилцан тохиролцох, улмаар судалгаа шинжилгээ явуулах замаар өөрсдийн нөөц бололцоог дайчлан ажиллах, тэвчиж болохуйц зардлыг ангилах, зарим хөрөнгө оруулалтыг хойшлуулах зэрэг чиглэлээр эрсдлээс гарах арга замыг эрэлхийлсээр байна.

Улсын төсөвт байгууллагын төсвийн зарлагын 2009 оны нэгдүгээр сарын гүйцэтгэлийн мэдээг төсвийн ерөнхийлөн захирагч нараар нэгтгэн гаргаж мэдээлэв. Улс, орон нутгийн төсөвтэй харилцагч төсөвт байгууллагуудын 2009 оны нэгдүгээр сарын гүйцэтгэлээр өглөг, авлагын мэдээг батлагдсан маягтын дагуу нэгтгэн гаргаж, ОУВС-д хүргүүллээ. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2009 оны нэгдүгээр сарын гүйцэтгэлээр (**2009 оны хоёрдугаар сарын 1-ний үлдэгдэл**) төсөвт байгууллагын төсвийн нийт авлага **7.1** тэрбум төгрөгт, төсвийн нийт өглөг **6.8** тэрбум төгрөгт хүрч, 2008 оны 12 дугаар сарын эхний үлдэгдлээс төсвийн авлага 86.0 сая төгрөгөөр буурч, төсвийн өглөг 2,223.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Төсвийн өглөг өсөхөд 2008 оны жилийн эцсийн тайлан тэнцлийг гаргах ажлын ачааллын улмаас зарим төлбөр тооцоог хугацаандаа багтааж гүйцэтгээгүй; төрийн сангийн 2009 оны төлбөр тооцоо 1 дүгээр сарын 10-наас эхэлж хийгдсэн байдал; улсын төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт тааруу байсантай холбогдуулан төсөвт байгууллагын зардлын санхүүжилтэд хязгаарлалт хийсэн зэрэг хүчин зүйл нөлөөлсөн байна.

Улсын төсөвт төв, орон нутгийн байгууллагын 2009 оны 2 дугаар сарын батлагдсан төсвийн хуваарийг Засгийн газрын санхүүгийн удирдлагын мэдээллийн нэгдсэн сүлжээнд зөөвөрлөн оруулж, төсвийн зарцуулалтын эрхийн баталгаа болон төвлөрүүлэн захирагч нарын зарцуулалтын эрхийн дэд баталгааг хянаж, түүнийг нэгдсэн сүлжээнд суулган төсөвт байгууллагын зардлын төлбөр тооцоо гүйцэтгэх, урсгал зардалд хяналт тавих бололцоог

хангасан байна. Төсвийн орлогын бүрдүүлэлттэй уялдуулан тухайн сарын эхний 10 хоног, дунд 10 хоног, сүүлийн 10 хоногт зарцуулах зардлыг ангилан хуваарийг зөвшөөрч, төсөвт байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр төрийн сангийн төлбөр тооцоо, мөнгөн хөрөнгийн удирдлагыг зохицуулан мөнгөн хөрөнгийн өдөр тутмын оролт, гаралтын урсгалыг тооцож, түүнийг эх үүсвэрээр хангах арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Батлагдсан төсвийн хуваарийн дагуу улс, орон нутгийн төсөвт байгууллагын 2009 оны хоёрдугаар сарын төсвийн урсгал зардлын эрхийг хянаж, 2009 оны хоёрдугаар сарын урсгал зардалд (өссөн дүнгээр) **138.0** тэрбум төгрөгийн санхүүжилт олгох арга хэмжээ авлаа. **Тухайлбал**, халамжийн тэтгэвэрт 4,542,3 сая төгрөг, тэтгэврийн нөхөн олговорт 17.4 сая төгрөг, тэтгэврийн даатгалын сангийн татааст 39,583.0 сая төгрөг, хүүхдийн мөнгөн тэтгэмжид 21,322.7 сая төгрөг, шинээр төрсөн хүүхдийн мөнгөн тусламжид 930.0 сая төгрөг, шинэ гэр бүлийн мөнгөн тусламжид 2,218.0 сая төгрөг, алдар цолтой ахмад настанд олгох нэмэгдэлд 1,373.7 сая төгрөг, жирэмсэн ба нярай хүүхэдтэй эхчүүдэд олгох тэтгэмжид 2,600.0 сая төгрөг, улс, орон нутгийн төсөвт байгууллагын урсгал төсвийн санхүүжилтэд 65412.9 сая төгрөгийг олгосон болно.

Засгийн газрын нөөц сан, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн хураангуй ба дэлгэрэнгүй тайланг нэгтгэн гаргаж, дүнг долоо хоног тутам удирдлагад тайлагнаж байна. Засгийн газрын шийдвэрийн дагуу 2009 оны 2 дугаар сард Засгийн газрын нөөц сангаас **63.3** сая төгрөгийг зарцуулсан байна. Түүнчлэн 2009 оны 2 дугаар сард санхүүгийн дэмжлэгээр 1,839.1 сая төгрөгийг хуваарилан олгосон байна. Батлагдсан хуваарийн дагуу улсын төсвөөс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 2009 оны 2 дугаар сарын гүйцэтгэлээр (өссөн дүнгээр) 13,712.8 сая (тухайн сард 2,465.5 сая төгрөг)-ийн санхүүжилт олгосон байна.

### **Байгаль орчин, аялал жуулчлалын салбарт:**

Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Гадаад харилцааны сайдын хамтарсан тушаалаар баталсан “Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, худалдах журам”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалаар баталсан “Химийн аюултай бодисын ангилал”, “Химийн хорт бодисын ангилал”, “Химийн хорт болон аюултай бодисын ангиллыг ашиглах аргачлал”, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаалаар баталсан “Химийн хорт болон аюултай бодисын ангиллын жагсаалт”, “Хог хаягдлын улсын тоо бүртгэл хөтлөх, тайлагнах журам”, мэдээний маягтуудыг нөхөх зааврыг тус тус Хууль зүй дотоод хэргийн яаманд бүртгүүлэв.

Энэ сард байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээг 40 төсөлд хийж Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний 22 тайланг батлав. Зургаан аж ахуйн нэгж байгууллагад химийн бодис импортлох, ашиглах зөвшөөрөл олгов. “Амьтныг шинжлэх ухааны зориулалтаар барьж, тэмдэглэх журам”-ын дагуу судалгааны хэрэгсэл зүүх зорилгоор Өмнөговь аймгийн Ноён, Гурван тэс сумын нутгаас 3 толгой цоохор ирвэс түр барих зөвшөөрлийг “Ирвэс хамгаалах сан” ТББ-д олгосон байна.

59 аж ахуйн нэгж байгууллагын 2008 оны Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн ажлын тайланг хүлээн авлаа. Эдгээр аж ахуйн нэгж байгууллагууд 2008 оныг хүртэл нийт 5895.4 га талбайд олборлолт явуулж эвдрэлд оруулснаас 2008 оны байдлаар 3645.3 га-д техникийн нөхөн сэргээлт хийж, мэдээ ирүүлсэн аж ахуйн нэгжүүдийн нөхөн сэргээлт 61.8 хувьд хүрч байна.

Энэ сард 30 аж ахуй нэгж байгууллага 2009 оны Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр батлууллаа. Батлагдсан хөтөлбөрийн үзүүлэлтээс үзэхэд шинээр 101.09 га талбай олборлолтонд өртөж, 121.93 га талбайд техникийн, 93.4 га талбайд биологийн нөхөн сэргээлтийн ажил хийхээр төлөвлөж, нөхөн сэргээлтийн баталгаа болгож 87.12 сая төгрөг төвлөрүүлсэн байна.

“Ногоон хэрэм” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр бүх шатны сургууль, цэцэрлэгүүдийн дунд зарласан “Ногоон төгөл” уралдааны дүнг гаргахад оролцсон байгууллагууд 400.000 гаруй мод бут тарьж, 5100 м<sup>2</sup> талбайг зүлэгжүүлснээс гадна сургууль, анги танхимаа цэцэгжүүлэн 20000 гаруй сав цэцэг тарьж ургуулжээ. Мөн 19 гудамж, талбай,

цэцэрлэгүүдийг хариуцан хамгаалж, арчлан ургуулж байгаагаас гадна Туул, Булган голын ай сав газрын унаган төрх, хэв шинжийг нь хамгаалсан байна.

Төв аймгийн Мөнгөнморьт сумын 6 нөхөрлөлийн ойн бүртгэл тооллогын тайлан, ойн менежментийн төлөвлөгөө, 2 аж ахуйн нэгжийн ойн тооллого бүртгэлийн тайланг 1:50000 масштабтай ойн тархалтын зурагийг ой усны хайгуул судалгааны төвөөс гүйцэтгэж хүлээлгэн өгсөн байна.

Мянган-Угалзатын болон Мөнххайрханы БЦГ-уудын дотоод бүсчлэл, орчны бүсийн хилийн заагийг тогтоов. Богдхан уулын дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд газар ашиглаж буй газрын төлбөрийн зөрчилтэй 23 иргэн, аж ахуйн нэгжүүдэд газрын төлбөр барагдуулах хугацаат албан шаардлага хүргүүлснээс 4 иргэн, аж ахуйн нэгж 6691000 төгрөгийн газрын төлбөрийг барагдуулсан байна. Орхоны хөндийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа Байгаль хамгаалагчдыг чадавхижуулах жилийн хүрээнд “Хүн төвтэй байгаль хамгаалал” ТББ-тай хамтран байгаль хамгаалагчдад GPS-ийн сургалт зохион байгуулж, дижитал аппаратаар хангажээ.

Монгол алтайн нурууны улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа, Баян-Өлгий аймгийн байгаль орчны албанаас явуулсан судалгаагаар Дэлүүн сумын Хөх сэрхийн нуруунд туурайтан амьтны өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Баян-Өлгий аймгийн засаг даргын тамгын газрын санхүүгийн дэмжлэгтэйгээр Алтай таванбогд, Сийлхэмийн нуруу, Цамбагаравын БЦГ-дад 800 боодол өвс, 2.0 тонн нунтаг давс тавьж биотехникийн арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

Дөргөний Усан цахилгаан станц ажилласнаас хойш загас өнгөрөөх сувгийг огт ажиллуулахгүй байгаа нь байгаль экологт сөрөг нөлөө үзүүлж байгаа тул Хар-Ус нуурын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаанаас усан цахилгаан станцын захиргаатай хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж байна. Байгаль хамгаалагч нарын орчин зүйн ажиглалтаас үзэхэд цас ихтэй ургамлын гарц муу гарснаас хар сүүлт, монгол бөхөн, цоохор ирвэс зэрэг ан амьтан тал руу бууж байгаа тул хамгаалалтын захиргаанаас хамгаалалтыг чангатгах арга хэмжээ авч байна.

Хөвсгөлийн улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын захиргаа 2009 оныг иргэдтэйгээ хамтран ажиллах жил болгон уриалга гаргаж биотехникийн арга хэмжээг 9 удаа 14 цэгт хийж, 9 цэгт харз ус задгайлж, 5 цэгт чонын ав тойлго хийж, ажиглалт судалгааг 15 удаа хийж гүйцэтгэжээ.

Цаг агаар хүндэрсэн үед тусгай хамгаалалттай газар нутагт мал өвөлжүүлэх ажлыг зохион байгуулдаг уламжлалын дагуу энэ жил Отгонтэнгэрийн улсын тусгай хамгаалалттай газрын хязгаарлалтын болон орчны бүсийн Идэр суманд 17054, Алдархаан суманд 3372, Отгон суманд 2889 мал тус тус өвөлжиж байгаа бөгөөд Идэр, Алдархаан сумдад отроор 1827 мал өвөлжиж байгаа дүнтэй байна.

Говь-Алтай аймгийн нийт нутгийн 70 гаруй хувь нь гантай, гандуу байснаас өвөлжилтийн байдал хүндэрч зарим нутагт аргаль хонь, янгир ямаа өлдөж үхэж хорогдох нөхцөл бий болсонтой холбогдуулан нэмэлт өвс тэжээл, хужир мараа тавих биотехникийн арга хэмжээг байгаль хамгаалах “Салхин сандаг” нөхөрлөлтэй гэрээ байгуулан зохион байгуулж байна. Тэрчлэн тус аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас зохион байгуулан Тайшир сумын “Улаан боом” гэдэг газарт мөсөөр хүрээлэгдсэн /арал/ ууланд байсан 20 гаруй янгир ямаанд 50 боодол өвс тавьж өгчээ.

Дархан-Уул аймгийн байгаль орчны алба Аймгийн хэмжээнд байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ, иргэдийн уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулж, аймгийн байгаль орчны ТББ-уудын зөвлөлийг 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулж, цаашид хийж хэрэгжүүлэх, ажлын талаар харилцан санал бодлоо солилцож хамтран ажиллахаар болов.

Аялал жуулчлал. Аялал жуулчлалын салбарын удирдах ажилтны зөвлөлгөөнийг анх удаа теле хэлбэрээр Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд зохион байгууллаа. Аймгуудын Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга, аялал жуулчлалын асуудал хариуцсан мэргэжилтнүүд, нийслэлийн дүүргийн байцаагч нар зэрэг 100 гаруй төлөөлөгч оролцлоо.

**Зам тээвэр, барилга, хот байгуулалтын салбарт:**

Зам, тээврийн бодлогын чиглэлээр. Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдсантай холбогдуулан тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох ажлын харъяаллыг Замын цагдаагийн газраас Авто тээврийн газарт шилжүүлэх асуудлаар Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан яамдын саналыг авч Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэв.

Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Автотээврийн газрыг байгуулсантай холбогдуулан “Автотээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” хуулийг 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр УИХ-аар батлуулав. Мөн тус агентлаг байгуулагдсантай холбогдуулан зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон бүтэц орон тооны талаар санал боловсруулав.

“МИАТ” ХК-ийн талаар Засгийн газарт танилцуулах бэлтгэл ажлын хүрээнд “МИАТ” ХК-ийг хувьчлах, хувьчлахгүй байх, компанийн удирдах үйл ажиллагааг удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэн, үр дүнг харгалзан хувьчлах гэсэн гурван чиглэлээр санал боловсруулан, яамдаас санал авахаар, “МИАТ” ХК-ийн санхүү, эдийн засгийн байдлын талаарх танилцуулгыг Төрийн өмчийн хороонд хүргүүлэв.

ИНЕГ-ын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарын саналыг боловсруулан шийдвэр гаргуулах шатанд байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агенлаг Төмөр замын газрын бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлтийн хөтөлбөрийг ЗТБХБ-ын сайдын тушаалаар батлав.

“УБТЗ” ХНН-ийн Ерөнхий хувь нийлүүлэгчдийн хурлыг 2009 оны 2 дугаар сарын 4-5-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулж, энэхүү хурлын протоколыг харилцан тохиролцож холбогдох талуудаар баталгаажуулав.

“Хөлөг онгоцны тэнцвэржүүлэгч ус болон үлдэгдэл тунадасны хяналт ба менежментийн тухай 2004 оны олон улсын конвенцид нэгдэн орох тухай” хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд УИХ-ын холбогдох байнгын хороогоор хэлэлцүүлэхээр шийдвэрлэв.

“Далайн нэхэмжлэлийн хариуцлагыг хязгаарлах тухай 1976 оны конвенци болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан 1996 оны протоколд нэгдэн орох тухай” хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлэв.

“Далайн хиймэл дагуулын Олон Улсын байгууллагын 1976 оны конвенци болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулсан 1981 оны протоколд нэгдэн орох тухай”, “Хөлөг онгоцны шатахууны савны тосны бохирдлоос учирсан хохирлын төлөө хүлээх иргэний хариуцлагын тухай конвенцид нэгдэн орох тухай”, “Хөлөг онгоцны будагнаас далайд учруулах хор хөнөөлд тавих хяналтын тогтолцооны тухай олон улсын конвенцид нэгдэн орох тухай” хуулиудийн төслийн үзэл баримтлалыг ХЗДХЯ-аар батлуулаад байна.

Зам, тээврийн зохицуулалтын чиглэлээр. Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яам, БНСУ-ын “Daewoo bus global corporation”-ны хооронд байгуулсан гэрээний дагуу Улаанбаатар хотын нийтийн зорчигч тээврийн үйлчилгээнд зориулж 400 автобус нийлүүлэгдэхээс эхний ээлжийн 20 ширхэг автобусыг хүлээн авах ёслолын үйл ажиллагааг 2009 оны 2 дугаар сарын 22-нд зохион байгуулж “Автобус-1” компанид хүлээлгэн өгөв.

Өвөрхангай аймгийн Хархорин хотноо 2 дугаар сарын 5-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Аялал жуулчлалыг Хангайн бүсийн хөгжлийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх зорилт, өнөө ба ирээдүй” сэдэвт Хангайн бүсийн зөвлөгөөн, Сэлэнгэ аймгийн Сүхбаатар хотноо 2 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулагдсан “Төвийн бүсийн хөгжилд эрчимжсэн газар тариалангийн гүйцэтгэх үүрэг” сэдэвт Төвийн бүсийн зөвлөгөөнд оролцож, “Хангайн болон төвийн бүсийн хөгжлийн хөтөлбөр”-т тусгагдсан зорилтуудад зам, тээвэр, барилга, хот байгуулалт, газрын харилцааны чиглэлээр хийж гүйцэтгэсэн биет ажлууд болон цаашид хийхээр төлөвлөж буй асуудлын талаар танилцуулав.

“МИАТ” ХК-ийн Аэробус-310, хоёр ширхэг Боинг-737 агаарын хөлгийн 2009 оны иж бүрэн даатгалын хураамжийг төлөөгүйгээс даатгалын гэрээг цуцлах нөхцөл байдал үүсээд байгаа, улмаар олон улсын нислэг зогсоход хүрч болзошгүй талаар “МИГ даатгал” компаниас

мэдэгдсэний дагуу асуудлыг анхааралдаа авч, шийдвэрлэх арга хэмжээ авахыг “МИАТ” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга болон компанийн удирдлагад даалгав.

Агаарын харилцааны асуудлаар БНСУ-ын талтай уулзалт хэлэлцээ хийх тов болон хэлэлцэх асуудлын саналыг Гадаад харилцааны яам, БНСУ-аас Монгол Улсад суугаа Элчин сайдын яаманд мэдэгдэв. 2009 оны 3 дугаар сард багтаан уулзалт хэлэлцээ зохион байгуулах, уг уулзалт хэлэлцээгээр нислэгийн суудлын багтаамжийн асуудлыг хэлэлцэх, Монгол Улсын Засгийн газар, БНСУ-ын Засгийн газар хоорондын “Агаарын харилцааны тухай хэлэлцээр”-т нэмэлт, өөрчлөлт оруулсан асуудлыг тодруулах юм.

Улаанбаатар хотын шинэ олон улсын нисэх буудлыг байгуулах төслийн зөвлөх компанийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог 2 удаа хуралдуулж, тендерийн баримт бичиг, зөвлөх компанийн жагсаалтыг эцэслэн тохирч, Сангийн яам, Японы JICA байгууллагаас холбогдох зөвшөөрлийг авсан. Сонгон шалгаруулалтын урилга, тендерийн баримт бичгийг зөвлөх компаниудад хүргүүлсэн. Сонгон шалгаруулалтад оролцох материалуудыг хүлээн авах хугацааг 2009 оны 4 дүгээр сарын 3-ны өдрийн 14:00 цагаар тасалбар болгосон болно.

Барилга, орон сууц, нийтийн аж ахуйн бодлого, зохицуулалтын чиглэлээр. “Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг ХЗДХЯ-аар батлуулж, хуулийн төсөлд яам, тусгай газруудаас санал авахаар хүргүүлээд байна.

Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжаар 2009 оноос хэрэгжүүлэх Дархан хотын ус хангамжийн байгууламжийг сайжруулах төслийн Зөвлөх компанийн төлөөлөгчидтэй уулзаж төслийн хүрээнд хийх ажлуудыг тохиролцов.

Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр баруун 5 аймагт 1998-2003 онд хэрэгжсэн “Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйг хөгжүүлэх МОН-1560 төсөл”, төвийн болон зүүн бүсийн 8 аймагт 2003-2008 онд хэрэгжсэн “Орон нутгийн хотуудын нийтийн аж ахуйн хөгжлийн 2 дахь үе шат МОН-1907 төсөл”-ийн зээлийн гэрээний дагуу эдгээр 13 аймгийн нийтийн аж ахуйн байгууллагуудын цэвэр, бохир усны үнэ тарифыг нэмэгдүүлэх, түүнтэй холбогдон төсөвт байгууллагуудад нэмж шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улс, орон нутгийн төсөвт тусгах, зээлийг хэрхэн төлөх асуудлыг шийдвэрлүүлэхээр Сангийн яаманд албан бичиг хүргүүлэв.

Барилгын тухай хуулийн дагуу “Барилгын ажлыг эхлэх, үргэлжлүүлэх дүрэм”, “Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”, “Барилгын ашиглалтын дүрэм”, “Барилгын захиалагчийн дүрэм”, “Барилга, байгууламжийн норм, нормативын баримт бичгийн тогтолцоо” гэсэн 5 дүрэм, журмыг шинэчлэн боловсрууллаа.

Японы ЖАЙКА байгууллагын тусламжаар хэрэгжүүлж буй Улаанбаатар хотын ерөнхий төлөвлөгөө, хот байгуулалтын хөтөлбөрийн судалгааны төслийн дунд хугацааны тайлан, эцсийн тайлангийн төсөлд санал өглөө.

Санхүү, эдийн засгийн хүндрэлтэй байдлыг харгалзан хүчингүй болгох, үйлчлэлийг нь түр зогсоох шаардлагатай тушаал, шийдвэрийн жагсаалтад Барилга хот байгуулалтын сайдын 210-р тушаал, зам, барилгын ажилчдын тарифт цалингийн жишгийг оруулахаар Сангийн яамнаас санал ирүүлсэнтэй холбогдуулан уг тушаалыг цаашид хэвээр мөрдөх, түүний үндэслэл, тайлбар танилцуулгыг бэлтгэж Сангийн яаманд хүргүүлэв.

Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын чиглэлээр. Газар зохион байгуулалтын ажлын үнэлгээг шинэчлэх тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулан сайдын зөвлөлийн хуралд танилцуулахад бэлэн болгов.

Улаанбаатар хотын ундны эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд орон сууцны зориулалтаар барилга барихаар газар олгогдсон Нийслэлийн Засаг даргын шийдвэрийг хянаж үзэх тухай ЗТБХБ-ын сайдын албан тоотыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчид хүргүүлэв.

Геодези зураг зүйн болон газрын кадастрын чиглэлээр тусгай зөвшөөрөл олгох журам, Газар зохион байгуулалт, газрын кадастрын үйл ажиллагаа эрхлэх мэргэжлийн байгууллагыг сонгон шалгаруулах журам, гэрээний төслүүдийг боловсруулан санал авч байна.

“Кадастрын зураглал ба газрын бүртгэл төсөл”-ийн хүрээнд Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Завхан, Увс, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Баян-өлгий аймгуудын төв суурин болон

газар тариалангийн кадастрын зураглал, газрын бүртгэлийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулагдаж, тендерийг зарлалаа.

“Аймаг дундын отрын бүс нутаг тогтоох тухай” Засгийн газрын тогтоолын төсөлд Засгийн газрын гишүүдээс санал авч Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлээ.

Цагаан нуурын чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөөний материал, ажлыг Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын газрын хэмжээнд хэлэлцэж санал дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна.

БНХАУ-ын 300 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд 100 сая ам.долларын зээлээр баригдах Цементийн үйлдвэр, Арматур төмөрлөгийн үйлдвэр болон Улаанбаатар хотын “Орон сууцны 7-р хороолол, МҮОНРТ-ийн орчмын хороолол”-ын инженерийн дэд бүтцийн ТЭЗҮ-ийг Улаанбаатар хотын захирагчийн ажлын албатай хамтран боловсруулсан.

Гадаад хамтын ажиллагааны талаар. ЗТБХБЯ болон ХБНГУ-ын Техникийн хамтын ажиллагааны нийгэмлэгийн “Хотын хөгжил, барилгын салбар болон мэргэжлийн боловсролын салбарыг дэмжих” хөтөлбөр хооронд “100 000 айлын орон сууц” төслийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллах тухай Санамж бичиг байгуулав.

“Транзит Монгол” олон улсын чуулга уулзалт зохион байгуулах хөтөлбөр, танилцуулга боловсруулан батлуулж, ОХУ, БНХАУ, ХБНГУ, БНСУ, Япон, Казахстан, Канад улсуудын холбогдох яам, газруудад хүргүүлэх ажлыг зохион байгуулж байна.

Төмөр замын салбарт хамтран ажиллах хамтарсан аж ахуйн байгуулах асуудлаар ажлын хэсэг байгуулагдан ОХУ-ын “РЖД” НХН-ийн төлөөлөгчидтэй хэлэлцээ хийж эхлэв.

### **Эрдэс баялаг, эрчим хүчний салбарт:**

Эрдэс баялаг, эрчим хүчний салбарын талаар Улсын Их Хурлаас баталсан хууль, тогтоол, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмж, Засгийн газрын тогтоол, хуралдааны тэмдэглэл, албан даалгавар, Ерөнхий сайдын захирамж, бусад шийдвэрийг хэрэгжүүлэх, биелэлтийг хангуулах арга хэмжээг тухай бүр авч ажиллав.

Таван толгойн нүүрсний орд газрыг эдийн засгийн эргэлтэд оруулах талаар олон улсын зөвлөх компанийг шалгаруулав.

Цагаан суваргын зэс-молибдений ордын хайгуулын ажлын тайлан, техник, эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан төсөлд шүүмж гаргахаар ажлын хэсэг ажиллаж байна.

2010 онд шинжлэх ухаан технологийн сангаас санжүүлэх төслийн захиалгыг салбарын холбогдох байгууллагуудаас авч нэгтгэн Боловсрол, соёл, шинжлэх ухааны яаманд хүргүүлэв.

Мөн 2009 онд эрдэс баялаг, эрчим хүчний салбарт “Шинжлэх ухаан технологийн сан”-гийн хөрөнгөөр санхүүжиж эхлэх 8 төслийн гүйцэтгэгчтэй байгуулах гэрээг хянаж баталгаажуулав.

Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн барих цогцолборын төсөлд гадны зөвлөх авах талаарх хүсэлтээ Сангийн яаманд хүргүүлээд байна.

“Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв” төрийн өмчит үйлдвэрийн газрыг байгуулахаар, сэргээгдэх эрчим хүчний үүсгүүрээр хангагдсан сумдын нар, салхи, нар-салхины хосолсон станцуудын эзэмшлийн асуудлыг шийдвэрлүүлэхээр тус тус Төрийн өмчийн хороонд хүргүүлээд байна.

Түүнчлэн сэргээгдэх эрчим хүчний чиглэлээр Улсын төсвийн болон Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн бүх арга хэмжээнүүдэд мэргэжлийн байгууллага, хөндлөнгийн шинжээчдийн хамтарсан дүгнэлт гаргах ажлын хэсгийг байгуулах бэлтгэлийг ханган ажиллаж байна. ХБНГУ-аас ирсэн хөндлөнгийн шинжээчид Баянхонгор, Говь-Алтай аймгуудад ажиллаж байна.

Говь-Алтай аймгийн Цогт, Баянхонгор аймгийн Баянбулаг сумын 15 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцын зураг төсөл боловсруулах даалгавар олгов.

Нүүрс олборлох тусгай зөвшөөрөл бүхий 20 уурхайн 2009 оны уулын ажлын төлөвлөгөөг хянан батлав.

Германы KFW банкны хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн хүрээнд Дарханы дулааны цахилгаан станцын турбогенераторыг шинэчлэх төслийн зөвлөх

үйлчилгээ үзүүлэх тендерийн эхний 2 шатны шалгаруулалтыг хийж, 3 дахь шатны үнэлгээг хийх талаар тохиролцож байна.

Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хорооны дүрмийг шинэчлэн боловсруулав.

Уул уурхайн салбарын жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн “Хариуцлагатай уул уурхай” сэдэвт зөвлөлгөөнийг зохион байгуулав. Үүнд 100 гаруй жижиг, дунд уул уурхай эрхлэгчид оролцож, ашигт малтмалыг байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй, эдийн засгийн үр ашигтайгаар олборлоход зайлшгүй мэдвэл зохих хууль эрх зүй, эдийн засаг болон бусад шаардлагатай мэдээллийг хүлээн авч, харилцан санал солилцов.

Төв аймгийн Борнуур суманд бичил уурхайн загвар үйлдвэрийг ашиглалтад хүлээн авав. Энэ нь тус суманд алтны үндсэн ордын хүдрийг нэг цэгт төвлөрүүлэн боловсруулах аж ахуйн нэгжийг үүсгэн байгуулж бичил уурхайчдын ажлын байрыг хадгалах, үндэсний хэмжээнд загвар болохуйц бичил уурхайн менежментийг хөгжүүлэх замаар нийгмийн сэтгэл зүйд үүсээд байгаа сөрөг имиж, төсөөллийг арилгах, хөдөөгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах ажлын эхлэл болж байгаа юм.

“Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил”-ийн хүрээнд зохион байгуулагдсан “Монголд үйлдвэрлэл” үзэсгэлэн, худалдаанд уул уурхай, хүнд үйлдвэрийн чиглэлээр 15 аж ахуйн нэгж оролцож, 2 нь гран при шагнал хүртэв.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулагдсан “Аялал жуулчлалыг хангайн бүсийн хөгжлийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх зорилт: Өнөө ба ирээдүй” сэдэвт Хангайн бүсийн зөвлөлгөөнд оролцож салбарын үйл ажиллагаанд хамаарах асуудлаар илтгэл тавьж, мэдээлэл хийв.

“Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хууль, “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нэмэлт оруулах тухай” хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төсөл, Засгийн газрын хуралдааны шийдвэрийн төслийг бэлтгэж хүргүүлэв.

Оюутолгойн тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хийх хөрөнгө оруулалтын гэрээний төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаан, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэв.

Бүтээгдэхүүн хуваах долоон гэрээг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлд хүргүүлэв.

“Монгол Улсын геологийн гавьяат ажилтан” цол шинээр бий болгох танилцуулга, Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Засгийн газрын шийдвэрийн төсөлд яамдын саналыг авч байна.

Геологийн бүх шатны судалгааны ажилд мэргэжлийн үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж өгөх мэргэжилтний эрх, үүрэг, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх “Геологийн салбарын мэргэжилтэнд мэргэшлийн зэрэг олгох” журам, дүрмийн төслийг боловсруулав.

Өөрийн орны нүүрсийг боловсруулан бензин шатахуун, хий болон химийн үйлдвэрлэлийн түүхий эд гарган авах асуудлаар Олон улсын эрчим хүчний агентлагтай хамтран ажиллах тухай саналыг Гадаад харилцааны яаманд хүргүүлэв.

Дархан, Эрдэнэтийн дулааны цахилгаан станцуудыг нүүрсээр урт хугацаанд тогтвортой хангах талаар Засгийн газарт танилцуулах саналыг бэлтгээд байна.

Монгол Улсад гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдийн 2009 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, зээл тусламжийн зарцуулалтын төлөвлөгөө, худалдан авах үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөл хэрэгжүүлэгч нэгжүүдийн үйл ажиллагааны зардлын төсвийг тус тус батлав.

2009 оны Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төсөл, арга хэмжээнд тайлбар, тодруулга өгөв. Түүнчлэн төсвийн тодотголд оруулах эрдэс баялгийн салбарын хөрөнгө оруулалтын ажлууд, тэдгээрийн тайлбар тооцоог сайдын багцад нэгтгүүлэв.

Эрчим хүчний алдагдалтай ажилладаг үйлдвэрүүдэд 2, 3 дугаар сарын алдагдлын татаасыг олгоод байна. Үүнд: “Баруун бүсийн эрчим хүчний систем” хувьцаат компанид 200,0 сая төгрөг, Даланзадгадын дулааны цахилгаан станцад 67,0 сая төгрөг, Налайхын дулааны станцад 2 дугаар сарын 60,0 сая төгрөг, Багануурын дулааны станцад 100 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.

Эрчим хүчний үйлдвэрүүдэд олгосон алдагдлын санхүүжилтээс нэмэгдсэн өртгийн албан татвар авах тухай татварын байгууллагын шаардлагыг Сангийн яаманд уламжлан уг татварыг төлөхгүй байхаар шийдвэрлүүлэв.

Эрдэс баялаг, эрчим хүчний сайдаар батлуулсан худалдан авах ажиллагааны ерөнхий төлөвлөгөөний дагуу 2009 онд тус салбарт бараа, ажил, үйлчилгээ худалдан авах нийт 16 тендерийн үнэлгээний хороог байгуулав. 2009 оны Монгол Улсын төсвийн тухай хуульд тодотгол хийж байгаатай холбоотойгоор тендер зарлах боломжгүй байна. Сангийн яамнаас 2009 онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг түр хойшлуулах тухай албан тоотыг ирүүлсэн.

Завхан аймгийн Улиастай, Тосонцэнгэл сум, Говь-Алтай аймгийн төвийн эрчим хүчний үйлдвэрүүдэд 2009 онд хэрэглэгдэх дизелийн түлшний нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийн үнэлгээг хийж гэрээ байгуулах зөвшөөрөл аван гэрээний хэлэлцээр хийж байна.

### **Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт:**

“Хүнсний баталгаат байдал” үндэсний хөтөлбөрийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, Засгийн газрын 32 дугаар тогтоолоор батлав.

“Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”, “Улсын тэргүүний тариаланч” шалгаруулах тухай саналыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн, 34 дүгээр тогтоолоор шийдвэрлэв.

“Монгол Улсын малын үржлийн ажлын стратеги төлөвлөгөө” баримт бичгийг хэлэлцүүлж, холбогдох зөвлөмжийг гаргуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж байна.

ХХААХҮ-ийн сайдын зөвлөлийн хуралдаанаар “ХХААХҮ-ийн салбарыг эдийн засгийн хямралаас хамгаалах бодлогын чиглэл” баримт бичгийн төслийг хэлэлцэж, гишүүдийн саналыг тусган Ерөнхий сайдын зөвлөлд хүргүүлэв.

Мөн “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн тайланг хуралдаанаар хэлэлцүүлж, гарсан шийдвэрийг гаргуулан хэрэгжүүлэх арга хэмжээг авч байна.

Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг батлуулахаар ХЗДХЯ-нд хүргүүлэв.

“Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр”-ийн төсөлд санал авахаар яамдад хүргүүлэв.

“Орон нутагт үйлдвэр хөгжүүлэх чиглэл батлах тухай” Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулж, “Үйлдвэржүүлэлтийг дэмжих жил”-ийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцүүлэв.

“Салбарын шинжлэх ухаан, технологийн зөвлөл”-ийг шинэчлэн байгуулан, Зөвлөлийн ажиллах журмыг боловсруулж, батлуулан ажиллаж байна.

ХХААХҮ-ийн салбарын мэдээллийн сангийн стандарт, бүтцийг батлуулан мөрдөж эхлэв.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын удирдах ажилтны зөвлөлгөөнийг 2009 оны 2 дугаар сарын 12-13 ны өдрүүдэд зохион байгуулав. Уг зөвлөгөөний үеэр Мал эмнэлэг, үржлийн албаны удирдах ажилтны салбар зөвлөгөөнийг зохион байгуулав. Зөвлөгөөнд аймаг, нийслэлийн ХХААГ, Мал эмнэлгийн алба, Мал үржлийн алба болон бусад холбогдох байгууллагын удирдах ажилтнууд оролцлоо.

Аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газруудын 2008 оны ажлыг дүгнэж, салбарын шилдэгүүдийг шалгаруулан, шагналыг зөвлөгөөний үеэр гардуулав.

“Алтан төлийн эзэн”, салбарын хулгана жилийн “Есөн алдартан”-г шалгаруулан, шагналыг орон нутагт хүргэх, гардуулах ажлыг зохион байгуулав.

“Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн, худалдааг “Мишээл Экспо” төвд зохион байгуулж, 150 гаруй иргэн, аж ахуйн нэгж оролцож, 400 гаруй сая төгрөгийн борлуулалт хийв.

Хэрлэнбаян-Улааны аймаг дундын отрын бүс нутгийг өнжөөх талаар Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газартай, хамтран ажиллах төлөвлөгөөг тус отрын бүс нутагт өвөлждөг Төв, Дундговь, Говьсүмбэр, Хэнтий, Нийслэлийн 13 сум, дүүргийн Засаг дарга нарт хүргүүлэв. Аймаг дундын отрын бүс нутагт 2009 оны 2 дугаар сарын 15-ны байдлаар 10 аймаг нийслэлийн 24 сум дүүргийн 543 өрхийн 37225 бод мал, 332226 бог нийт 369451 толгой мал өвөлжиж байна.

Багахайрханд 17 тн, Хэрлэнбаян-Улаанд 1,5 тн багсармал тэжээл дараа төлбөр хийх нөхцөлтэйгээр олгож, малын хорогдол гарахаас урьдчилан сэргийлэхэд зохих туслалцаа үзүүлж байна. Одоогийн байдлаар 100,0 тонн багсармал тэжээл нөөцөд байна.



ОХУ-аас импортоор оруулж ирсэн улаан буудайг аж ахуйн нэгжид хуваарилан олгох ажлыг зохион байгуулж байна. Одоогоор 6 аж ахуйн нэгжид 564 тонн улаан буудай олгоод байна. Мөн техник тоног төхөөрөмжийг хуваарийн дагуу олгож байна.

Япон Улсын Ядуурлыг бууруулах сангийн санхүүжилтээр Азийн хөгжлийн банкнаас хэрэгжүүлэх “Ядуу малчин өрхүүдэд зориулан уст цэг ба нэвтрүүлэх төв байгуулах” төслийн эхлэлтийн семинарыг Өвөрхангай аймагт зохион байгуулан, санамж бичигт гарын үсэг зурж, төслийн үйл ажиллагааг эхлүүлэв.

Зохиомол хээлтүүлгийн 2008 оны ажил үйлчилгээний дүнг гаргаж, 2009 оны зорилтоо тодорхойлох зөвлөгөөний бэлтгэл ажлыг хангаад байна. 2008 онд 74 салбар ажиллуулан 3138 үнээ, 3510 хонь, 310 ямааг зохиомол хээлтүүлэгт хамруулсан ба үнээний хээл авалтыг 83 хувьд хүргэн ажиллав. Малын удмын сангийн үндэсний төвтэй байгуулсан гэрээгээ үр дүнтэй биелүүлж, мэргэжлийн ур чадвар гарган ажилласан техникчдийг урамшуулах ажлыг зохион байгуулав.

Монголын Хүнсчдийн Холбоо, Монгол Японы төвтэй хамтран “Архи спиртийн үйлдвэрлэлд чанарын хяналтын тогтолцоо нэвтрүүлэх” сэдэвт үзүүлэх сургалтыг зохион байгуулав.

“Согтууруулах ундааны үйлдвэрлэлийн техникийн зохицуулалт”-ын талаар лабораторийн ажилтнуудад зориулсан сургалтыг СХҮТ-тэй хамтран зохион байгуулав.

Монголын Хүнсчдийн холбоо, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчидтэй цаашид хамтран ажиллах талаар нээлттэй хэлэлцүүлгийг зохион байгуулж хамтран ажиллах төлөвлөгөөний төслийг боловсруулав.

Орон нутагт үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэл, байгуулах үйлдвэрүүдийн техник, эдийн засгийн үндэслэлийн эмхэтгэлийг хэвлүүлэн, хэрэглэгчдэд хүргүүлээд байна.

Монгол - Оросын хамтын ажиллагааг 2009 онд хөгжүүлэх арга хэмжээний тухай протоколын дагуу ОХУ-аас газар тариалангийн техник тоног, төхөөрөмж, үр бордоо зээлээр авах асуудлыг харилцан тохиролцов.

Япон Улсын Засгийн газар 2007 оны санхүүгийн жилд Монгол Улсад нийлүүлсэн улаан буудайн тусламжийн асуудлаар хоёр Засгийн газар хоорондын уулзалтыг 2009 оны 2 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулж, Япон Улсаас үзүүлсэн 16 удаагийн тусламжийн барааг борлуулсан орлогоос бүрддэг хуримтлалын сангийн ашиглалтын талаар болон цаашид хуримтлалын сангаар хэрэгжүүлэх төслийн талаар санал солилцов.

Японы JICA олон улсын байгууллагын дэмжлэгтэй хэрэгжиж буй “Мал аж ахуй, газар тариалангийн хосолсон загвар аж ахуйн хөгжлийг дэмжих төсөл”-ийн эцсийн шатны үнэлгээг төсөл хэрэгжүүлэгч 3 аймгийн 8 сумд 24 аж ахуйн нэгжид хийв. Тайланг төслийн хамтарсан Зохицуулах хорооны хурлаар хэлэлцэж, төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг 6 сараар сунгав. Стратеги нэвтрүүлэх төлөвлөгөөг боловсруулах асуудлыг хэлэлцэж ХХААХҮЯ, Сангийн яам, ЖАЙКА-ын хооронд 3 талын Протоколд гарын үсэг зурав.

#### **Гадаад харилцааны салбарт:**

Ерөнхийлөгч Н.Энхбаяр Давос хотноо 1 дүгээр сарын 28-31-нд зохион явагдсан “Дэлхийн эдийн засгийн чуулга уулзалт”-д оролцохдоо Чехийн Ерөнхийлөгч В.Клаус, Йоркийн гүн, хунтайж Эндрью, Литвийн Ерөнхийлөгч В.Адамкус, Францын “Арева” группын Ерөнхийлөгч хатагтай А.Лувержон, Швейцарийн Хөгжлийн хамтын ажиллагааны агентлагийн Ерөнхий захирал М.Дахинден нартай тус тус уулзав. Ерөнхийлөгч Н.Энхбаяр мөн Лихтенштейний Вант Улсад зочилж, Лихтенштейний Ван Хоёрдугаар Ханс-Адамтай уулзаж, хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов. Эдгээр уулзалтуудын үеэр хөндөж ярьсан хамтын ажиллагааны асуудлуудын талаар холбогдох байгууллагуудад зохих журмаар мэдээлэв.

Ерөнхий сайд С.Баяр ОХУ-ын Эрхүү мужид 2009 оны 1 дүгээр сарын 22-23-ны өдрүүдэд ажлын айлчлал хийв. Ерөнхий сайд С.Баяр Эрхүү хотноо ОХУ-ын Хөдөө аж Ахуйн сайд, ОХУ-ын ерөнхийлөгчийн тусгай бие төлөөлөгч, Монгол, Оросын ЗГХК-ын Оросын талын дарга А.В. Гордеев, Оросын Төмөр Зам НХН-ийн ерөнхийлөгч В.И. Якунин, Росатом корпорацийн ерөнхий захирал С.В. Кириенко нартай уулзаж яриа хэлэлцээ хийв. Мөн Эрхүү мужийн амбан захирагч И.Э. Есиповскийг хүлээн авч уулзав.

Ерөнхий сайд С.Баярын 3 дугаар сарын 19-29-ний өдрүүдэд Франц, Люксембургийн Их Вант Улс, Европын Холбоо, ХБНГУ зэрэг Европын зарим улсад хийх айлчлалын бэлтгэлийг ханган ажиллав.

Ерөнхий сайд С.Баяр БНПУ-ын Ерөнхий сайд Д.Тусктэй 2 дугаар сарын 16-нд утсаар ярьж, Монгол, Польшийн харилцаа, хамтын ажиллагааны асуудлаар санал солилцов.

Монгол Улсын Засгийн газрын урилгаар ОХУ-ын Бүгд Найрамдах Халимаг Улсын Тэргүүн К.Н.Илюмжинов 2009 оны 2 дугаар сарын 2-4-ний өдрүүдэд Монгол Улсад албан ёсны айлчлал хийв. Айлчлалын үеэр Ерөнхийлөгч Н.Энхбаярт бараалхаж, хоёр улсын харилцааны байдал, төлвийн талаар санал бодлоо солилцов.

Гадаад харилцааны сайд С.Батболд, ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.В.Лавровын урилгаар 2009 оны 1 дүгээр сарын 25-28-ны өдрүүдэд ОХУ-д албан ёсны айлчлал хийв. Гадаад харилцааны сайд С.Батболд ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.В.Лавровтой хэлэлцээ хийв. Хэлэлцээний үеэр сайд С.Батболд Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяраас ОХУ-ын Ерөнхийлөгч Д.А.Медведевийг 2009 оны 8 дугаар сард тэмдэглэх Халх голын байлдааны хамтын ялалтын 70 жилийн ойн үеэр төрийн айлчлал хийж, баярын ажиллагаанд оролцохыг урьсан албан ёсны урилгыг ОХУ-ын Гадаад хэргийн сайд С.В.Лавровт гардуулав.

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын Комиссын Худалдааг либералчлах Ажлын хэсгийн VIII хуралдааныг 2009 оны 2 дугаар сарын 5-ний өдөр ОХУ-ын Москва хотноо хуралдуулав.

Монголын хөнгөн, нэхмэлийн аж үйлдвэрийн зарим барааг ОХУ-ын худалдааны хөнгөлөлтийн системд хамруулах асуудлаар дэлгэрэнгүй судалгаа, мэдээлэл гаргах чиглэлээр ажиллав.

БНХАУ-ын Худалдааны яамны Гадаад хөрөнгө оруулалт, эдийн засгийн хамтын ажиллагааны газраас ирүүлсэн “Ажиллах хүч харилцан солилцох тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийн тухай ноотыг НХХЯ-нд хүргүүлэв.

Монгол Улс, БНХАУ-ын нийслэлд хоёр улсын Соёлын төв харилцан байгуулах тухай хэлэлцээр байгуулах эсэх асуудлаар судалгаа хийж байна.

Монгол, Хятадын хилийн Гашуун сухайт-Ганц мод, Булган-Такашикэн боомтыг байнгын ажиллагаанд шилжүүлэх, Монгол, Оросын хилийн Боршоо-Хандгайт боомтыг олон улсын зэрэглэлтэй болгох асуудлаар санал боловсруулав.

Монгол, Хятадын хилийн Гашуун сухайт-Ганц мод, Баянхошуу-Өвдөг боомтыг 2009 онд бүтэн жилийн турш ажиллуулахаар хятадын талтай тохиролцсоныг хилийн болон холбогдох хяналтын байгууллагуудад мэдэгдэв.

Япон Улсаас Монгол Улсад олгох буцалтгүй тусламжийн хүрээнд Төслийн бус буцалтгүй тусламж, “Хархорины музей барих” төсөл, “Дархан хотын усан хангамжийг сайжруулах” төсөл, “Бага, дунд боловсролын сургуулийн барилга, өргөтгөл барих” төслийн 4 дэх үе шат, “Улаанбаатар хотын төмөр замын гүүрэн гарц барих” төслийн нарийвчилсан зураг төсөл зэрэг нийт 6 төслийн баримт бичигт 2009 оны 1 дүгээр сарын 22-нд Гадаад харилцааны сайд С.Батболд, Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайд Я.Ичихаши, JICA-ийн суурин төлөөлөгч Ю.Ишида нар тус тус гарын үсэг зурав.

Монгол, БНСУ-ын ГХЯ-ын зөвлөлдөх уулзалтыг 3 дугаар сарын 2-нд Сөүл хотноо хийхээр Солонгосын талтай тохирч бэлтгэлийг хангаж ажиллав.

Иргэдийн зорчих нөхцөлийг харилцан хөнгөвчлөх тухай Монгол Улсын Гадаад харилцааны яам, Бүгд Найрамдах Солонгос Улсын Гадаад хэрэг, худалдааны яам хооронд солилцов. Ноот бичиг соёрхон батлах тухай хуулийн төслийг УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны анхны хэлэлцүүлгээр хэлэлцүүлж, УИХ-ын нэгдсэн чуулганаар хэлэлцүүлэх шийдвэр гаргуулав.

Швейцарийн холбооны улс 2008 оны 12 дугаар сарын 12-ны өдрөөс Шенгений хэлэлцээрт нэгдэн орж, 2009 оны 1 дүгээр сараас Шенгений виз олгож эхэлсэнтэй холбогдуулан хувийн хэргээр тус улсад зорчиж буй Монгол Улсын иргэд Бээжин хотод очиж виз мэдүүлэх нь санхүүгийн болон цаг хугацааны хувьд ихээхэн хүндрэлтэй болж байгааг харгалзан үзэж Улаанбаатар дахь БНФУ-ын ЭСЯ-тай ярилцаж тохиролцсоны дагуу ШХУ-д нэвтрэх визийг Улаанбаатарт олгуулах хүсэлтийг к/09-147 ноотоор тавьж 2009.01.30-ны 08/381 тоот албан бичгээр Бээжин дэх ЭСЯ-нд хүргүүлэв.

Монгол Улс, Европын Холбооны хооронд хэвтээ тэнхлэгийн хэлэлцээр байгуулах асуудлаар 2 дугаар сарын 19-нд Бельгийн Вант Улсын Брюссель хотноо болсон хоёр талын уулзалтын бэлтгэлийг ханган ажиллав.

ЕвроАзийн Эдийн засгийн хамтын нийгэмлэгт ажиглагчаар элсэх талаар судалгаа хийж, тус нийгэмлэгт нэгдсэнээр экспортын барааны нэр төрөл цөөхөн орны хувьд худалдааны тэнцлийн зөрүү хэрхэн нэмэгдэх, татварт ордог орлогын хэмжээ буурах талаар судалгаа хийж ЕвроАзийн эдийн засгийн хамтын нийгэмлэгт ажиглагчаар оролцох тухай асуудлыг Засгийн газарт танилцуулав.

### **Батлан хамгаалах салбарт:**

Стратегийн удирдлага, төлөвлөлтийн чиглэлээр. “2009 онд цэргийн дүйцүүлэх албанд элсүүлэх иргэдийн тооны дээд хязгаарын тухай, “Мөнгөн төлбөрийн дээд хэмжээ тогтоох тухай” асуудлуудыг Засгийн газрын 2009 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэлээ.

“Косово Улсад НҮБ-ын мандаттайгаар НАТО-гийн хэрэгжүүлж буй энхийг сахиулах ажиллагаанд Зэвсэгт хүчний цэргийн баг оролцуулах тухай”, 2010 онд явуулах “Дайчилгаатай команд-штабын сургуулийн тухай” асуудлуудыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.

“Зэвсэгт хүчний материал хэрэгслийн цувраажилтын норм шинэчлэх тогтоох тухай” асуудлыг боловсруулан сайдын тушаалаар баталгаажуулахаар ажиллаж байна.

“Зэвсэглэл, техникийг шинэчлэх дунд, урт хугацааны бодлого” баримт бичгийн төслийн эхний хувилбарыг боловсруулж байна.

Яам, аймаг, нийслэлийн дайчилгааны төлөвлөгөөг орон нутгийн эдийн засаг, нийгмийн бүх салбар дахь гол үзүүлэлтүүдийг Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөөний тодотголд тулгуурлан тодотгох, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг даалгаваржуулахад мэргэжлийн дэмжлэг тусалцаа үзүүлэн ажиллаж байна.

Бодлогын хэрэгжилтийг зохицуулах чиглэлээр. ЗХЖШ-аас үндсэн хөрөнгийн данснаас хасуулахаар санал болгосон зэвсэглэл, техник, материал хэрэгслийн байдалд Зэвсэгт хүчний анги, салбаруудаар явж үзлэг шалгалтыг 4 анги, байгууллагуудад явууллаа.

2009 оны хэрэгцээнд урсгал төсвийн зардлаар худалдан авах бараа, ажил үйлчилгээ /хүнс, шатахуун, хувцас, эм ороох боох материал/-ний бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах тендерийг зарлаж, хуулийн дагуу 2 дугаар сарын 23-ны өдөр нээлтийг зохион байгуулсан.

Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэр байрлах Зэюсэгт хүчний 326 дугаар ангийн офицер, ахлагч нарын ахуйн зориулалтаар эзэмшиж байгаа газрын кадастрын зургийг хийлгэлээ.

Баянзүрх дүүргийн засаг даргын захирамжаар офицер, ахлагч, ажилтнуудад газар эзэмшүүлсэн гэрчилгээг гардуулах ажиллагааг зохион байгуулах ажлын хүрээнд 150 айлын газар эзэмших гэрчилгээг олголоо.

Батлан хамгаалахын сайдын 2009 оны төсвийн багцын сарын хуваарийг баталгаажуулан харьяа агентлаг, төсөвт байгууллагуудад хүргүүлэн хуваарийн дагуу санхүүжилт хийгдэж байна.

Гадаад хамтын ажиллагааны чиглэлээр. Батлан хамгаалахын сайдын БНЭУ-д албан ёсны айлчлал хийлээ. Айлчлалын үеэр БНЭУ-ын Батлан хамгаалахын сайд А.К.Антонитай уулзаж, хоёр орны батлан хамгаалах салбарын харилцаа, хамтын ажиллагаа, өнөөгийн түвшин цаашдын хөгжлийн чиг хандлага, агуулга хэлбэрийг баяжуулах талаар харилцан санал солилцлоо.

Монгол-Энэтхэгийн цэргийн тусгай хүчний хамтарсан “Нүүдэлчин заан” хээрийн сургуулийг уламжлал болгон зохион байгуулах, хоёр орны батлан хамгаалах салбарын дээд хэмжээний уулзалт, төлөөлөгч солилцох, ажлын уулзалт хийх, цэргийн сургалт болон цэргийн хамтарсан сургуулиуд, боловсон хүчнийг бэлтгэх зэрэг салбарт хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэх талаар ярилцлаа.

БНЭУ-ын Шинэ Дели хотноо Монгол-Энэтхэгийн Батлан хамгаалах яам хоорондын 2 дугаар зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, хамтын ажиллагааны өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт өгч, цаашдын чиглэлийг тодорхойлов.

Бэлэн байдал, байлдааны бэлтгэл сургалтын талаар. “Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангах ЗХЖШ-ын төлөвлөгөөнд тусгагдсан 2008 онд хэрэгжүүлсэн цэргийн дэд төсөл, хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн дүгнэлт хийж, ЗХЖШ-аас 2009 онд хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг шинэчлэн гаргалаа.

Монгол Улсын цэргийн болзошгүй ажиллагааны зүүн бүсийн цэрэг-стратегийн орчны үнэлгээг хийж, Дорнод, Сүхбаатар аймгуудын нутаг дэвсгэр дэх ашигт малтмалын ордуудад олзворлолт явуулж байгаа газруудыг түшиглэн цэргийн анги, салбар шинээр байгуулах асуудлаар тандалт судалгаа хийж, дүгнэлт гарган гаргалаа.

2008-2009 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу Зэвсэгт хүчний стратегийн нэгдсэн команд штабын сургуулийн бодлого-төлөвлөгөөг боловсруулан батлуулж, 2 дугаар сарын 18-20-ны өдрүүдэд “Хямралт байдлын үед Зэвсэгт хүчний ажиллагааг төлөвлөлт удирдлагаар хангах нь” сэдвээр удирдан явууллаа.

“Монгол Улсын агаарын орон зайн хяналт, удирдлагын автоматжуулсан систем КМ-2008” төслийн хүрээнд АДХЦ-ийн Удирдлагын төв байр, Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн хорооны удирдлагын байр, 323 дугаар салбарын удирдлагын байруудыг нэгдсэн сүлжээнд холбоход шаардлагатай тоног төхөөрөмж, пульт системийг суурилуулан 303, 065 дугаар ангиудын удирдлагын байрын бүрэлдэхүүнтэй сургалт зохион байгуулав.

2008-2009 оны сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийн үндсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу офицер, ахлагч нартай жигдрэлтийг хангах сургалт, гэрээт цэргийн I, II жилийн цэргийн албан хаагчидтай мэргэжлийн бэлтгэл, салбарын жигдрэлтийн сургалт, хугацаат цэргийн албан хаагчидтай цэргийн мэргэжил олгох болон олон талт үүргийн бэлтгэл сургалтыг зохион байгуулж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллалаа.

“Зэвсэгт хүчний байгуулалтыг 2015 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх зорилгоор БХИС-ийн Ахлагчийн сургуулийн хөтөлбөрөөр 314 ахлагчийг шаардлагатай мэргэжлээр сургаж бэлтгэх ажлын хүрээнд Зэвсэгт хүчний 013 дугаар ангид явагдаж байгаа мэргэжлийн ахлагч бэлтгэх төвийн сургалтын явцад хяналт тавьж, мэргэжлийн дэмжлэг үзүүлж ажиллалаа.

Сиерра Леон Улсад НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцож буй YII ээлжийн цэргийн багийн бүрэлдэхүүн болон Баруун Сахар, Судан, Гүржид НҮБ-ын явуулж буй энхийг сахиулах ажиллагаанд Зэвсэгт хүчний 9 офицер цэргийн ажиглагчийн үүргээ хэвийн гүйцэтгэж байна.

Сиерра Леон улсад явуулж байгаа НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагаанд оролцох YII ээлжийн цэргийн багийн бүрэлдэхүүний бэлтгэлийг хангаж, илгээсний гадна YI ээлжийн бүрэлдэхүүний угтан авах ажлыг зохион байгуулав.

### **Хууль, эрх зүйн салбарт:**

Иргэний болон худалдааны хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын гэрээ, Зарим цогцос оршуулах журам батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг бэлтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулав.

УИХ-ын гишүүн Ц.Даваасүрэн, З.Алтай, С.Бямбацогт, Д.Дондог, Ц.Сэвдэнчиг, А.Тлейхан нарын санаачилсан Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, УИХ-ын гишүүн Р.Гончигдорж, Ж.Сүхбаатар нарын санаачилсан Эрүүгийн байцаан шийтгэх хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, УИХ-ын гишүүн Н.Энхболдын санаачилсан Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төсөл, УИХ-ын гишүүн

Г.Баярсайхан нарын санаачилсан Өршөөлийн тухай хуулийн болон УИХ-ын гишүүн А.Тлейхан, Д.Оюунхорол, Ц.Даваасүрэн нарын санаачилсан Монгол Улсыг хөгжүүлэх сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдэд Засгийн газрын санал дүгнэлтийн төслийг бэлтгэн Засгийн газарт хүргүүлж, хэлэлцүүлэв.

Гаалийн хамтын ажиллагааны Зөвлөл байгуулах тухай Конвенцид оруулсан нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл өгсөн.

Чөлөөт бүсийн зөвлөл байгуулах тухай, Цэргийн дүйцүүлэх албанд 2009 онд элсүүлэх иргэдийн тооны дээд хязгаар, цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний жилийн төлөх төлбөрийн дээд хэмжээг тогтоох тухай, Хөрөнгө гаргах тухай, Ус ашигласны төлбөрийн хувь хэмжээг шинэчлэн тогтоох тухай зэрэг Засгийн газрын 17 шийдвэрийн төсөлд санал өгсөн.

Засгийн газрын 2007 оны 13 дугаар албан даалгаврыг хэрэгжүүлэх хүрээнд 2009 оны 2 дугаар сарын 17-ны өдрийг “Нээлттэй өдөр” болгон тус яам болоод харъяа агентлагийн төлөөлөл оролцсон нэгдсэн өдөрлөгийг тус яаман дээр, харъяа агентлаг байгууллагууд өөрийн байгууллага дээрээ зохион байгуулав.

Дээрх арга хэмжээний хүрээнд залуучуудыг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор хийгдсэн “Ухаарал” богино хэмжээний уран сайхны киноны нээлтийн ажиллагааг хийж киног хамтран бүтээсэн Хууль зүй, дотоод хэргийн яам, Ханнс Зайделийн сан, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн төлөөлөл болон кинонд тоглосон Кино урлагийн дээд сургуулийн оюутнууд оролцов.

Түүнчлэн [WWW.E-HUTUCH.GOV.MN](http://WWW.E-HUTUCH.GOV.MN) вэб хуудас болон эрх зүйн туслалцааны төвүүдийн чиг үүрэг, үйл ажиллагааны талаарх танилцуулга хийгдэж, Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс гаргасан хууль эрх зүйн чиглэлийн номын худалдаа зохион байгуулагдсан.

Хууль зүй, дотоод хэргийн яамны мэргэжилтнүүд болон эрх зүйн туслалцааны төвийн өмгөөлөгчид иргэдэд хууль зүйн зөвлөгөө өгөх, тодорхой асуудлаар санал хүсэлтийг хүлээн авсан бөгөөд давхардсан тоогоор нийт 350 орчим хүн хамрагдав.

Дэлхийн банкны Захиргааны шийдвэрийг стандартчилах төсөлтэй хамтран аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн дарга нарт зориулсан сургалт семинарыг 2009 оны 2 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд зохион байгуулав.

Тайлангийн хугацаанд албан болон хувийн хэргээр түр буюу удаан хугацаагаар ирэх гадаадын иргэдэд холбогдох төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хүсэлтийг үндэслэн орох 679, орох гарах 16, олон удаагийн 116, нийт 811 гадаадын иргэнд олгох визийн зөвшөөрлийг Гадаад хэргийн яамны консулын газарт өгч, гарах-орох 2029, гарах 2000, олон удаагийн 423 виз олгосон.

Монгол Улсад оршин суух, дамжин өнгөрөх, бүртгэл, хөдөлмөр эрхлэх журам зөрчсөн болон визийн хугацаа хэтрүүлсэн зэрэг зөрчил гаргасан гадаадын 19 орны 229 иргэнд “Захиргааны хариуцлагын тухай” хуульд заасны дагуу 38 сая 450 мянган төгрөгийн мөнгөн торгууль ногдуулсан байна.

Гадаадын орнуудаас урьсан иргэнээ зохих хугацаанд бүртгүүлээгүй, хууль бусаар хөдөлмөр эрхлүүлсэн, визийн хугацааг хэтрүүлсэн, нуун далдалсан зэрэг зөрчлийн улмаас 24 байгууллага, аж ахуйн нэгжид 19 сая 300 мянган төгрөгийн мөнгөн торгууль ногдуулан улсын орлогод оруулсан байна.

## ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР